

Гарчиг

Хүснэгтийн жагсаалт	2
Зургийн жагсаалт	2
ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	4
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл	4
1.2. Толгойт дэд төвийн танилцуулга.....	5
1.2.1. Байршил	5
1.2.2. Төслүүдийн товч танилцуулга, хэрэгжилтийн байдал.....	6
1.2.3. Төслийн усан хангамж.....	9
1.2.4. Төсөлд ашиглах түүхий эд, материал.....	9
2. ТОЛГОЙТ ДЭД ТӨВИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ	10
2.1. Физик газарзүй	10
2.2. Уур амьсгалын үндсэн үзүүлэлт.....	11
2.3. Агаарын чанар	11
2.4. Геологийн тогтоц:.....	12
2.5. Гадаргын усны бүрэлдэх онцлог.....	12
2.6. Гидрогеологийн нөхцөл	12
2.7. Хөрсөн бүрхэвчийн онцлог, тархалт.....	13
2.8. Ургамлын нөмрөг	13
2.9. Амьтны аймаг.....	14
2.10. Тусгай хамгаалалттай газар нутаг	14
2.11. НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ.	14
3. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ БОЛОН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	16
3.1. Газрын гадаргад нөлөөлөх нөлөөлөл	16
3.2. Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл	21
3.3. Физик орчинд үзүүлэх нөлөөлөл.....	26
3.4. Гадаргын усанд үзүүлэх гол болзошгүй сөрөг нөлөөлөл	28
3.5. Газрын доорх усанд үзүүлэх гол болзошгүй сөрөг нөлөөлөл	30
3.6. Газрын доорх усны чанар.....	32
3.7. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл.....	33
3.8. Ургамлын нөмрөгт үзүүлэх нөлөөлөл	34
3.9. Ан амьтанд үзүүлэх нөлөөлөл	35
3.10. Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх нөлөөлөл	35
3.11. Түүх, соёлын өвд үзүүлэх нөлөөлөл	35
3.12. Нийгэм, олон нийтэд үзүүлэх нөлөөлөл	36
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ...37	37
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	41
5.1. Мэдээлэл холбооны шугам сүлжээ ба цахилгаан эх үүсвэрийн угсралт (TEC).	41
5.2. Дэд бүтцийн байгууламж (TRDH11-TRDH14)	48
5.3. Ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн талбайн ажил (SHTL).	65
5.4. Толгойт үерийн сувгийг тохижуулах багц ажил (tfp-a):.....	71
5.5. Салбар шугам холбох багц ажил- (SHTSC).....	75
5.6. Сургалтын төв барих ажил (tbc).	83
5.7. Ерөнхий боловсролын сургууль барих ажил (tsc + shtl-a).	88
6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	95
6.1. Техникийн нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ	95
7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	98
8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	98
9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ	99

10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	103
11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	105
12. ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР (ОХШХ)	107
13. БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ	115

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төслийн хүрээнд 2025 онд хэрэгжих дэд төслүүдийн мэдээлэл	6
Хүснэгт 2. Унд ахуйн усны хэрэглээ	9
Хүснэгт 3. Технологийн усны хэрэглээ	9
Хүснэгт 4. Ногоон байгууламжийн усалгаа	9
Хүснэгт 5. Толгойт ДТ-ийн газар шорооны ажлын шорооны материалын тооцоолол	17
Хүснэгт 6. Нөлөөллийн бүс	20
Хүснэгт 7. Экосистемийн ангилал	20
Хүснэгт 8. Амьдрах орчны төрөл	20
Хүснэгт 9. Ландшафтын нөхцөл	20
Хүснэгт 10. Газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ	20
Хүснэгт 11. Багц тус бүрээс гарах тоосжилтын хэмжээ	21
Хүснэгт 12. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээ	25
Хүснэгт 13. Машины механизмаас үүсэх дуу чимээний тархалтын эрчим	26
Хүснэгт 14. Физик орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээ	28
Хүснэгт 15. Гадаргын усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл	29
Хүснэгт 16. Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээ	32
Хүснэгт 17. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээ	34
Хүснэгт 18. Түүх соёлын өвд үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээ	35
Хүснэгт 19. Төслийн хэрэгжилт, гэрээ байгуулсан хугацаа болон дуусах хугацаа	38
Хүснэгт 20. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй	40
Хүснэгт 21. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө-(TEC-A, TEC-B, TEC-C)	41
Хүснэгт 22. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө. (TRDH11A, TRDH11B)	48
Хүснэгт 23. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө. (TRDH11C)	55
Хүснэгт 24. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (TRDH14A, TRDH14B)	58
Хүснэгт 25. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө SHTL-(C1-C5, D багц)	65
Хүснэгт 26. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (TFP-A багц)	71
Хүснэгт 27. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (SHTSC-A)	75
Хүснэгт 28. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (SHTSC-B)	78
Хүснэгт 29. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (TBC багц)	83
Хүснэгт 30. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ((TSC + SHTL-A багц)	88
Хүснэгт 31. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	95
Хүснэгт 32. Газар эзэмшлийн нөхцөл байдал	98
Хүснэгт 33. Нөхөн олговор олгосон байдал	98
Хүснэгт 34. Осол эрсдэлийн менежмент төлөвлөгөө. (Бүх багц)	99
Хүснэгт 35. Хог хаягдлын менежмент төлөвлөгөө. (Бүх багц)	103
Хүснэгт 36. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө. (Бүх багц)	105
Хүснэгт 37. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр. (TEC-A, TEC-B, TEC-C)	107
Хүснэгт 38. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр. (TRDH11A, TRDH11B, TRDH11C багц)	108
Хүснэгт 39. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр. (TRDH14A, TRDH14B)	109
Хүснэгт 40. ОХШХ (SHTL-C1, SHTL-C2, SHTL-C3, SHTL-C4, SHTL-C5, SHTLD)	110
Хүснэгт 41. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр. (TBC-толгойт дэд төв сургалтын төв)	111
Хүснэгт 42. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр. (TSC+SHTL-A)	112
Хүснэгт 43. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр. (SHTSC-A, SHTSC-B)	113
Хүснэгт 44. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр. (TFP-A)	114
Хүснэгт 45. БОМТ-ний хэрэгжилтийг оролцог талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	115

Зургийн жагсаалт

Зураг 1. Дэд төв, төслийн талбайн байршил	5
Зураг 2. Толгойт дэд төвийн газарзүйн байдал	11
Зураг 3. Монгол орны ургамал газарзүйн тойрог	13
Зураг 4. Төслийн талбай, түүний орчмын УТХГН ба ОНТХГН-ууд	14
Зураг 5. Толгойт дэд төвийн байршил, засаг захиргааны хил хязгаар	15
Зураг 6. Төслийн нөлөөлөл	16

Зураг 7. Замын барилгын ажлын үед үүсэх тоосны 24 цагийн дундаж агууламж	22
Зураг 8. Дулааны шугамын барилгын үед үүсэх тоосны 24 цагийн дундаж агууламж.....	23
Зураг 9. Цэвэр усны шугамын барилгын ажлын үед үүсэх тоосны 24 цагийн дундаж агууламж....	23
Зураг 10. Бохир усны шугамын барилгын ажлын үед үүсэх тоосны 24 цагийн дундаж агууламж .	24
Зураг 11. Хуваарилах болон нийгмийн барилга байгууламжийн барилгын үед үүсэх тоосны 24 цагийн дундаж агууламж	24
Зураг 12. Төслийн талбай орчмын гадаргын усан сүлжээ.....	29
Зураг 13. Төслийн талбай орчмын гидрогеологи.....	31
Зураг 14. Монгол орын цэвдгийн тархалт	31

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хот 1 сая 400 мянга орчим хүн амтай. Хотын төв хэсэг нь ихэвчлэн төвийн дулаан, усан хангамж, ахуйн хог хаягдлыг цуглуулах зэрэг цогц үйлчилгээгээр хангагдсан орон сууцны хорооллоос бүрдсэн. Төв хэсгийн эргэн тойронд 90 квадрат километр бүхий хүн амын нягтрал багатай, сул дэд бүтэцтэй хотын захын хороолол (гэр хороолол гэгддэг) байх бөгөөд хотын хүн амын 60 орчим хувь нь (ойролцоогоор 800,000 хүн) энэ бүсэд оршин суудаг. Гэр хорооллын хэмжээ шилжих хөдөлгөөний улмаас өргөжин тэлсээр байна. Гол төлөв бага болон дунд орлоготой айл өрхүүд эмх цэгцгүй хашаа барьж суурьшсан нь тодорхой төлөвлөлтгүйгээр шороон замуудыг ихээр бий болгож байна. Энд амьдарч буй өрхүүдийн дийлэнх нь газар эзэмших эрхтэй. Хотын суурь үйлчилгээ дутмаг байгаа нь иргэдийн эрүүл мэндэд хохирол учруулахуйц бохирдол үүсгэж байна, тухайлбал (I) өвлийн улиралд ихэнх гэр хорооллын оршин суугчид сайжруулаагүй нүүрсний зуух хэрэглэж байгаа нь агаарын маш их бохирдол үүсгэдэг; (II) айл өрхүүд зөвхөн ил бие засах газартай тул ариун цэвэр муу; (III) хатуу хог хаягдлын цуглуулалт тааруу учир амьдрах орчныг ихээр бохирдуулж байна. Мөн түүнчлэн ундны усны хүртээмж хязгаарлагдмал (ус түгээх зөөврийн худгуудаас хангагддаг). Улмаар гэр хороололд хотын үндсэн үйлчилгээ, нийтийн эзэмшлийн зай талбай, нийгмийн барилга байгууламж, худалдаа үйлчилгээний хэсэг болон эдийн засгийн үйл ажиллагаа явуулах таатай орчин нэн дутагдаж байна.

Азийн хөгжлийн банк (АХБ) 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөр нь олон салбарын оролцоог газар зүйн нэг байршилд татан уялдуулж, гэр хороололд хотын үндсэн үйлчилгээ, бизнесийн таатай орчин бүхий дэд төвийн сүлжээг бий болгох Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг болно. Хөтөлбөр төслөөр хотын үйлчилгээний өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээ, шаардлагыг хангах, гэр хорооллын хөгжлийг хурдасгагч хүч болох дэд төвийн сүлжээг хөгжүүлэх үйл явцыг хөгжүүлэхээр зорьж байна. Гэр хорооллын дэд төвүүдийн дэд бүтцийг сайжруулах, хотын төвтэй холбосноор хүмүүс болон бараа бүтээгдэхүүний урсгалыг нэмэгдүүлэх, хотжилтын зурвасыг хөгжүүлэх, дэд төвийн сүлжээг бий болгон тэгш боломжийг хангасан хотын хөгжилд нэн чухал ач холбогдолтой. Тэргүүлэх ач холбогдолтой авто зам дагуух дэд бүтцийн сүлжээг хамруулан төлөвлөлтийг сайжруулснаар дэд төвүүдэд хотжилтын бүтцийн шинэчлэлийг эхлүүлнэ. Ингэснээр (i) оршин суугчдыг хотын үндсэн үйлчилгээ, нийтийн эзэмшлийн талбай болон нийгэм- эдийн засгийн байгууламжаар хангах, (ii) дэд төвийн эдийн засгийн хөгжлийг дэмжих; (iii) хотын эдийн засгийн харилцаанд оролцон үр шимийг нь хүртэх боломжийг оршин суугчид болон бизнесүүдэд олгох, (iv) орон сууцны нөхцөлийг дээшлүүлэх боломжтой болно. Газар ашиглалтад нааштай өөрчлөлт гарч, хүн амын нягтрал нэмэгдсэнээр суурьшлын бүсэд усан хангамж, ариутгах татуурга, дулаан хангамжийн үйлчилгээ сайжирна.

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр: Толгойт дэд төв

Төслийн дугаар: 13/3270

Төслийн зорилго, зорилт: Гэр хороололд орон сууц, хүүхдийн цэцэрлэг, хотын дэд бүтцийн үйлчилгээ хангамж бүхий эрүүл, аюулгүй, тав тухтай амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлсэн, бие даан хөгжсөн дэд төвийн сүлжээг бий болгоход төслийн зорилго оршино.

Төсөл хэрэгжүүлэгч: “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн нэгж”

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Сүхбаатар дүүрэг 8-р хороо, Бага тойрог-1, Амарын гудамж-2, Соёлын төв өргөө Г корпус/415 тоот.

Холбоо барих утас: 9103-3373, 9976-7000-3099,

Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг:

Төслийн зохицуулагч: Д.Авирмэд


Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг:

З.Мөнх-Оргил, 70003099, munkh-orgil@ub-subcenter.mn

1.2. Толгойт дэд төвийн танилцуулга

1.2.1. Байршил

Толгойт дэд төв нь нийт 551,4 га газар нутгийг хамрах бөгөөд засаг захиргааны хувьд Сонгинохайрхан дүүргийн 1, 2, 3, 20, 35 дугаар хороод багтдаг.



Зураг 1. Дэд төв, төслийн талбайн байршил

1.2.2. Төслүүдийн товч танилцуулга, хэрэгжилтийн байдал

Толгойт дэд төв төслийн хүрээнд нийт 24 ажил хамаарч байгаагаас 2023 онд 4 ажил, 2024 онд 7 ажил хэрэгжүүлж эхэлснээс 1 ажил хэрэгжиж дууссан, үлдсэн 6 ажил үргэлжилж, шинээр 13 ажил барилга угсралтын гэрээ байгуулж, 2025 онд нийт 19 ажил хэрэгжихээр байна. Төслийн хүрээнд 2025 онд хэрэгжих дэд төвүүдийн мэдээллийг Хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгт 1. Төслийн хүрээнд 2025 онд хэрэгжих дэд төслүүдийн мэдээлэл

№	Багцын дугаар	Багцын нэр	Хийгдэх ажил
2023 онд хэрэгжиж дууссан төслүүд			
1	SC-A	Дэд төвийн байршлын талбайн цэвэрлэгээний ажил (1-р шат, 2-р шат)	160 нэгж талбар Баянхошуу, Дамба, Толгойт
2	SC-B		
3	SHTSC	Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй сургууль цэцэрлэгүүдийн дэд бүтцийг бие даасан дэвшилтэд технологиор шийдвэрлэх ажил	Хийн халаалтын зуух суурилуулах ажил - 9ш сургууль Нөөц цахилгаан үүсгэвэр суурилуулах ажил - 4 сургууль Ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах ажил - 5ш сургууль Бохир усны саармагжуулах төхөөрөмж суурилуулах ажил - 1ш сургууль
4	TFP	Толгойт дэд төвийн үерийн усны хамгаалалтын суваг (1-р хэсэг)	Толгойт дэд төвийн үерийн хамгаалалт, ус зайлуулах • Үерийн усны хамгаалалтын суваг • Тунгаах байгууламж 2ш • Далд хоолой 2 байрлалд • Одоо байгаа далд хоолойг өргөсгөх 1 байрлалд Автомашин болон явган хүний гарц 2 байрлалд
2024 онд хэрэгжиж дууссан төсөл			
1	SHTSC-C	Дэд төвүүдийн бохир ус, дулаан хоёрдогч холболт	Ариутгах татуургын шугам – 1.5км Дулаан хангамжийн шугам – 1 км
2025 онд үргэлжлэх төслүүд			
1	TBC	ТДТ сургалтын төв	Тэнхлэгээрээ 50.0 х 33.0 м хэмжээтэй, хагас нум хэлбэртэй болон тэгш өнцөгтийн блокоос бүрдсэн 2 давхар, 2081 м ² талбай
2	TRDH11C	ТДТ-ийн насосын станц болон усан шугам сүлжээ	- Усан хангамжийн сүлжээ - Ус хангамжийн шугам хоолой ба худгууд - Насос станц Q=4600м3/х - Насос станцын иж бүрэн барилга байгууламж, гадна тохижилт, зам талбай Одоо байгаа цахилгааны 10кВ, 0.4кВ-н кабель шугамыг шилжүүлэх, буулгах ба шинээр татах
3	SHTSC-A	Толгойтын ус, бохир ус, дулааны хоёрдогч холболт (Цэргийн хотхон)	Ф530х8мм-ийн голчтой 1.3 км дулааны шугамын угсралтын ажил
4	SHTSC-B	Баянхошуу дэд төв(Оргил)-ийн цэвэр, бохир ус, халуун ус, дулаан түгээх шугам сүлжээний нийлүүлэлт, суурилуулалт	Ариутгах татуургын шугам - 3км Гадна цэвэр усны шугам - 1,6км Дулаан хангамжийн шугам - 2км УДДТ-2ш
5	TFP-A	ТДТ-ийн үерийн усны хамгаалалтын суваг (2-р хэсэг)	- ТДТ-д (Баруун наран) үерийн хамгаалалт, ус зайлуулах хоолой - Үерийн усны хамгаалалтын суваг Автомашин болон явган хүний гарц 5 байрлалд

			далд хоолой	
6	TSC+(SHTL-A)	ТДТ-ийн бага сургууль. 320суудалтай, Ерөнхий боловсролын дунд сургууль	<ul style="list-style-type: none"> - Буулгалтын ажил 1958 онд ашиглалтад орсон дан давхар 386.5м² хичээлийн байр буулгах. - Гадна тохижилтын ажил нийт 5820м² талбайд автозам, явган зам талбай, эргийн бэхэлгээ, дугуйн зам, дугуйн зогсоол, сүүдрэвч, гэрэлтүүлэг, бялдаржуулах талбай, тавцант гулгуурын талбай, авто зогсоол, ногоон байгууламжаас бүрдэнэ. <p>Зоорины давхартай, 3 давхар 640 хүүхдийн сургуулийн барилга. Нийт талбай 4704.6м² гадна инженерийн шугам сүлжээ</p>	
2025 онд шинээр эхлэх төслүүд				
1	TEC	A	ТДТ-ийн мэдээлэл холбооны шугам сүлжээ	<ul style="list-style-type: none"> - Холбооны худаг сувагчлал, шилэн кабель 8.1км - Холбооны цамхаг 25-30м - Мэдээлэл холбооны нэгдсэн үйлчилгээний төв - 2 давхар зоорьтой - Мэдээлэл холбооны байр - 1 давхар зоорьтой
2		B	ТДТ-ийн цахилгааны хаалттай дэд өртөө ба 10кВ цахилгаан дамжуулах кабель шугам	<ul style="list-style-type: none"> - Хаалттай дэд өртөө 2*630кВА - 10/0.4 кВ-н - 8 иж бүрдэл - 10кВ-ын хос кабель шугам - 8.1км
3		C	ТДТ-ийн цахилгааны хуваарилах байгууламжууд ба 10кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугам	<ul style="list-style-type: none"> - ПРП дэд станцын 10кВ-ын хуваарилах байгууламжийг буулгах - 1ш - ПРП дэд станцын 10кВ-ын хуваарилах байгууламжийг шинээр барих - 1ш - "ПРП" дэд станцаас ТДТ хүртэлх 10кВ-н 4 хос кабель шугамын ажил - 13км - Хаалттай дэд өртөө 2*630кВА 10/0.4 кВ-н - 2 иж бүрдэл - 10кВ-ын хуваарилах байгууламж - 2 иж бүрдэл
4	TRDH11	A	ТДТ-д хийгдэх ариутгах татуургын шугам суурилуулалтын ажил	<ul style="list-style-type: none"> - Бохирын шугам хоолой /Ф100-1000мм/ - 4710м - Бохир усны худаг /Ф1000-2000мм/ - 77ш - 10/0.4кВ цахилгаан, холбооны кабель, шугам зөөж шилжүүлэх - Дулаан, цэвэр усны шугамыг хүчитгэх - А2 авто зам 2177м
5		B	ТДТ-ийн авто замын ажил	<ul style="list-style-type: none"> - Авто зам А4 хэсэг 633м урт авто замын ажил, А5 300м урт автозам 444м² авто зогсоол, автобусны буудалтай
6	TRDH14	A	ТДТ-ийн авто зам, дулааны сүлжээ болон бусад дагалдах ИШС (1-р хэсэг)	<ul style="list-style-type: none"> - СХД-ийн 1, 2-р хорооны нутаг дэвсгэрийн ТДТ дэх 1.3 км урт А2 Авто замын ажил; - Ф100мм-Ф500мм хүртэл голчтой 1.14 км Гадна ариутгах татуургын угсралтын ажил - 1.5 км урт Ф100мм-Ф300мм хүртэл голчтой Гадна дулааны шугам сүлжээний ажил; - 966м урт Ф50мм-Ф300мм хүртэл голчтой Гадна цэвэр усны шугам угсралтын ажил; - Ус дулаан дамжуулах төв №2,№3,№4-ын барилга угсралтын ажил; - Кабель шугам, эрчим хүчний байгууламжийг хүчитгэх, шилжүүлэх, буулгах ба шинээр татах ажлууд
7		B	ТДТ-ийн авто зам, дулааны сүлжээ болон бусад дагалдах ИШС (2-р хэсэг)	<ul style="list-style-type: none"> - СХД-ийн 1, 2-р хорооны нутаг дэвсгэрийн ТДТ дэх 0.473км урт А2 Авто замын ажил; - Ф100мм-Ф500мм хүртэл голчтой 1.14 км Гадна ариутгах татуургын угсралтын ажил - 2.15км урт Ф32мм-Ф350мм хүртэл голчтой Гадна дулааны шугам сүлжээний ажил;

				<ul style="list-style-type: none"> - 2.63км урт Ф50мм-Ф300мм хүртэл голчтой Гадна цэвэр усны шугам угсралтын ажил; - Ус дулаан дамжуулах төв №1 ба №5-ын барилга угсралтын ажил; - Кабель шугам, эрчим хүчний байгууламжийг хүчитгэх, шилжүүлэх, буулгах ба шинээр татах ажлууд 	
8	SHTL	C	1	<p>СХД-ийн 8-р хорооны 50 айлын орон сууцны барилгын урд талбайн бичил тохижилт болон СХД-ийн 9 дүгээр хороонд 3x3 сагсан бөмбөгийн талбайн тохижилт</p>	<ul style="list-style-type: none"> - 50-айлын урд талбайн тохижилт: Уг талбайд явган хүний зам 246 м², саравч 1 ширхэг, тоглоомын талбай /6 сар-4 нас/ 87 м², усан оргилуур 1ш, ногоон байгууламж 398 м² байхаар тус тус төлөвлөв. Ногоон байгууламж 398кв.м буюу нийт тохижилтын талбайн 54.2% эзлэхээр төлөвлөв. - Сагсны талбай: Уг талбай нь “3x3” төрлийн спортын талбай бөгөөд үндсэн тоглолтын талбай нь 13.9x17.9м хэмжээтэй байна. Хашаан дотроо 1.5м өргөнтэй явган хүний зам, 2 ширхэг сандал, 1ширхэг хогны сав байна. Хашааны өндөр 3.5м төмөр сараалжин. Төв замаас сагсны талбай руу холбогдох явган замтай.
9			2	<p>СХД-ийн 10-р хороонд бичил тохижилтын ажил</p>	<ul style="list-style-type: none"> - Уг талбай нь хүүхэд залуучуудад зориулсан жижиг хэмжээний экстрим талбайтай, хаданд авиралтын ханатай, 2 саравч, 3 сандал, 1 хогны сав, 1.5м өргөнтэй явган зам, явган зам дагуух ногоон байгууламж хэсэгтэй. Нийт талбайн 47.31% буюу 231.32м²ногоон байгууламж, 9.98% буюу 43.93м² явган зам, 40.68% буюу 194.02м² экстрем талбай, 2.18% буюу 10.69м² хаданд авиралтын хана байна.
10			3	<p>СХД-ийн 8-р хороо, нийслэлийн 261 дүгээр цэцэрлэгийн гадна нэмэлт авто зогсоолын ажил”</p>	<ul style="list-style-type: none"> - 261-р цэцэрлэгийн хажуугийн авто зам дагуух газар 21 машины зогсоол төлөвлөсөн. 2 зогсоол нь тэргэнцэртэй иргэний авто машины зогсоол байна. Нийт талбайн 50.95% буюу 981.13м² авто зогсоол, 48.56% буюу 935.26м² ногоон байгууламж, 0.49% буюу 73.81м² явган зам талбай байна. Авто зогсоол нь байгалийн шигтгэмэл чулуу байна.
11			4	<p>СХД-ийн 8-р хороо, бизнес инкубатор төвийн гадна нэмэлт авто зогсоолын ажил</p>	<ul style="list-style-type: none"> - Бизнес инкубатор сургалт үйлдвэрлэлийн төвийн хажууд 13 машины зогсоол төлөвлөсөн. 1 зогсоол нь тэргэнцэртэй иргэний авто машины зогсоол байна. Авто зогсоол нь байгалийн шигтгэмэл чулуу байна.
12			5	<p>СХД-ийн 8-р хороо, Баянхошуу бизнес инкубатор төв болон нийслэлийн 261 дүгээр цэцэрлэгийн барилгын гадна фасадны засварын ажил</p>	<ul style="list-style-type: none"> - Бизнес инкубатор сургалт үйлдвэрлэлийн төвийн хажууд 13 машины зогсоол төлөвлөсөн. 1 зогсоол нь тэргэнцэртэй иргэний авто машины зогсоол байна. Авто зогсоол нь байгалийн шигтгэмэл чулуу байна.
13		D	<p>Сэлбэ дэд төв дэх нийтийн зориулалттай ногоон байгууламж ба гадна талбайн тохижилтын ажлууд</p>	<ul style="list-style-type: none"> - Багц 1- Сүхбаатар дүүргийн 14-р хороо, 35-р сургуулийн арын тохижилт: Нийт 1266м² талбайтай, явган зам 390.72м², спорт талбай 420м², дасгалын талбай 152.27м², саравч 3ш, 6-4 насны тоглоомын талбай 147.73м², 5-12 насны хүүхдийн тоглоомын талбай 152.27м², ногоон байгууламжийн талбай 625.15м² - Багц 2 - Сүхбаатар дүүргийн 14-р хороо, 50 айлын баруун талд 3x3 сагсан бөмбөгийн талбай: Нийт талбай 800м² байгууламж ба гадна талбайн тохижилтын ажил - 50 айлын 	

				орон сууцын зүүн хойд талд 0.025 га талбайд “3х3” төрлийн сагсан бөмбөгийн талбайн ажил
--	--	--	--	---

1.2.3. Төслийн усан хангамж

Толгойт дэд төвийн барилгын ажил болох 24 багц ажлын хүрээнд 18-21 компани барилгын ажил гүйцэтгэхээр байна. Тухайн газар ажиллах хүн хүчний хувьд нэг компани /Аж ахуйн байгууллага/ 20-30 хүнтэй гэж тооцвол нийт 360-630 хүн ажиллах болно. Барилгын ажлын хүрээнд ашиглах усыг төвлөрсөн шугам болон УСУГ-ын харьяа гүний худгуудаас авч хэрэглэнэ. Толгойт дэд төвийн цэвэр усан хангамж нь дараах эх үүсвэртэй бөгөөд 3–р үе шатны хүрээнд СХД-ийн 1,2, 3 болон 34,35 дугаар хороонд Төвлөрсөн шугамд холбогдсон 12 ширхэг худаг, Ахуйн хэрэглээний 44 худаг байна.

Хүснэгт 2. Унд ахуйн усны хэрэглээ

№	Хэрэглэгч	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Усны норм /л/	Хэрэглээ /м ³ /		
					Хоног	Сар	Жил /6 сар/
1	Ажилчид	л/хоног	495	80	39.6	1188	7128
	Нийт				39.6	1188	7128

Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм. БОНХАЖ-ын яамны А-301 тушаал. 11, 14-р, хавсралт

Барилгын ажлын хүрээнд тоосжилт үүсэх хэсэг, зам талбайн усалгаа хийгдэнэ. Барилгын ажлын үе шатнаас хамаарч тоосжилт дарах усалгаа хийгдэнэ. Жилд 14-16 удаа усалгаа хийнэ.

Хүснэгт 3. Технологийн усны хэрэглээ¹

№	Нэр	Тоосжилт үүсэх талбайн хэмжээ /м ² /	Усны норм /л/	Усалгааны тоо	Нийт хэрэглээ /жил/м ³ /
1	Толгойт дэд төв	11,561.5	4	16	739.936
	Нийт	11,561.5			739.936

Төслийн гадна тохижилтын ногоон байгууламжийн усалгаанд ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг цэвэршүүлэн ашиглах нь зүйтэй. Төслийн нийт 9100м² талбайн ногоон байгууламж бий болгоно. Ногоон байгууламжийн усалгааг дараах байдлаар тооцов.

Хүснэгт 4. Ногоон байгууламжийн усалгаа

№	Зориулалт	Усны норм /л/	Тоо хэмжээ	Усалгааны тоо	Жилд жил/м ³
1	Цэцэрлэг, зүлэг ногоо	4	9100	41	1,492.4
	Нийт				1,492.4

1.2.4. Төсөлд ашиглах түүхий эд, материал

Толгойт дэд төв төслийн бүс орчимд байрлах тусгай зөвшөөрөл бүхий түгээмэл тархацтай ашигт малтмалын орд газруудаас түүхий эд, материал татахаар төлөвлөж байна. Толгойт дэд төвийн хүрээнд Авто зам 4 эгнээ бүхий зам 1.97 км, 2 эгнээ бүхий зам 4.067км, дугуйн зам 5.9 км, Дулаан хангамжийн 6.728 км, Ариутгах татуургын 12.094 км шугам, цэвэр усны 7.38 км шугам, цахилгааны кабелийн 90.0 км шугам, холбооны 7.1 км шугам сүлжээ татах, Сургалтын төв, Эрүүл мэндийн төв барих, 5.375 км үерийн суваг тохижуулах зэрэг ажилд ашиглагдах хайрга, дайрга, элс, асфальт, цементийг тусгай зөвшөөрөлт байгууллагаас худалдаж авна.

¹ Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм. БОНХАЖ-ын яамны А-301 тушаал. 13-р, хавсралт

2. ТОЛГОЙТ ДЭД ТӨВИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ

2.1. ФИЗИК ГАЗАРЗҮЙ

Төслийн талбайн “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн “Толгойт бичил дэд төв” төслийн талбай нь хотын баруун хэсэгт орших бөгөөд Улаанбаатар хот, түүний орчмын нутаг дэвсгэр нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Хэнтийн уулархаг мужийн баруун урд үзүүрт Туул голын хөндийн 2.5 4 км хүртэл өргөсөж тохойрсон татам болон дэнжийн хэсэгт байрладаг. Газарзүйн байршлын хувьд ойт хээрийн бүсэд багтдаг бөгөөд 1950-2268 м үнэмлэхүй өндөртэй Богдхан, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх зэрэг өндөр уулсаар хүрээлэгдэнэ. Улаанбаатар хотын ихэнх барилга байгууламж нь Туул голын хөндийн ай сав болон Сэлбэ голын адаг хэсэг, Зүүн, Баруун Наран, Цагаан хуарангийн дэнжид тархжээ. Түүнчлэн, Туул голын хөндийн өмнөд жигүүрт Их, Бага тэнгэрийн аманд төр, засгийн тусгай объектууд тодорхой хамгаалалтын бүсэд оршдог. Үүний зэрэгцээ Сэлбэ, Хөл, Бэлхийн голын хөндий, Туул голын Дээд Хар усан тохой, Могойн дэнж, Их Хуанди, Улиастай, Гачууртын голын адаг, Толгойтын голын Зүүн, Баруун салаа орчмоор хувийн орон сууцны зориулалттай бэсрэг цогцолбор, зуслангийн барилга байгууламж, гэр хорооллын объектууд нэлээд шигүү хэлбэрээр байрлаж байна.

Газрын гадарга: Хотгор гүдгэрийн хувьд тэгшрэлийн гадарга бүхий нэгэн уулсын системийг үүсгэх боловч гадаад хүчний нөлөөгөөр өөрчлөгдөн хувирсаар хэд хэдэн ширээ өндөрлөг болон гол, горхи ам хөндийгөөр ихээхэн хэрчигджээ. Уулсын хажуу нь тэгш бус байрлалтай хойд хажуу нь богиновтор, өмнөд хажуу нь урт ерөнхийдөө уулсын баруун хагасын хажуу нь эрс байна. Уулсын гадаргад хад чулуу, асга, чулуун нуранги элбэгтэй. Хотын баруун хойд хэсэг нь 1831 м өндөр бүхий Толгойт, 1800 м өндөр бүхий Чингэлтэйн салбар уулсаар хүрээлэгдэнэ. Эдгээр уулс нь харьцангуй мөлгөр оройтой бөгөөд өвөр хажуу нь аажим намссаар Мааньт, Тасганы овоо, Нарангийн толгодорхог гадаргууд шилжиж үнэмлэхүй өндөр нь багасаж улмаар Туул голын хөндийн хэсэгт тулж очдог. Хотын баруун талд тектоник-дендуцийн гаралтай 1652 м үнэмлэхүй өндөртэй Сонгинохайрхан, зүүн талд 1527 м үнэмлэхүй өндөртэй Баянзүрх уул оршино. Эдгээр уулс нь эгц хажуутай, хурц шовх оройтой, гарш хяруудыг үүсгэсэн байдаг. Дээрх өндөр уулсын муж болон уулс хоорондын хөндийн газрын гадаргын харьцангуй өндөршлийн зөрүү ихэвчлэн 400-500 м боловч заримдаа 700-920 м хүрдэг. Туул голын хөндийн ай савын татмын үнэмлэхүй өндөр 1250-1345 м бөгөөд өргөний хэмжээ 1.2-4.0 км байдаг. Толгойт, Баянхошуу, Баянцогт, Хойд Баян, Цагдуулт зэрэг нам уулсын мужийн үнэмлэхүй өндрийн хэмжээ 1515-1831 м ба тэдгээрийн хажуу ташлаг, энгэр, бэлийн налуу ихэвчлэн 15-20 хэм зарим тохиолдолд 30-35 хэм байдаг. Нэлээд өндөр өргөгдсөн уулсын мужийн хажуу ташлаг, энгэр, бэл, хормойг хөндлөн хэрчсэн олон тооны хуурай сайр, гуу жалга ховил түгээмэл ажиглагддаг.

Байгалийн бүслүүр: Хэнтийн нурууны уулархаг мужийн баруун өмнөд захад орших боловч өндрийн нөлөөгөөр ой, тайгын ландшафт голлох байр эзэлдэг. Богдхан уул нь манай орны зүүн хэсэг дэх ойн тархалтын хамгийн урд хэсэг болдог бөгөөд зүүн өмнөд ба өмнөд хэсгээрээ хуурай хээрийн ландшафттай залгадаг тул ургамал, амьтны зүйлийн тархалтын хувьд ихээхэн өвөрмөц юм. Амьтны газарзүйн мужлалын хувьд умардын их мужийн хөвч тайгын дэд муж, Хэнтийн тойрогт багтана.

Газар зүйн байдал: Зүүн бүс нутаг нь далайн түвшнээс дээш 1402-1407 метр өндөр жижиг толгодоор хүрээлэгдсэн байна. Хойд талаас горхи урсдаг. Харин Сэлбэ голын ойролцоох баруун талын газар нь далайн түвшнээс дээш 1350м-1737м өндөр, 0-6%-ийн налуутай байдаг. Бусад дэд төвүүдийн гэр хорооллын газар нутагтай харьцуулахад, Дамбадаржаа нь Сэлбэ голын сав газар, Мод үржүүлгийн газрын талбай гэх мэт хангалттай байгалийн ногоон бүстэй. Уулын бэл газар нь эгц налуутай байдгаас хотыг хөгжүүлэхэд саад болдог.



Зураг 2. Толгойт дэд төвийн газарзүйн байдал.

2.2. УУР АМЬСГАЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Төслийн талбай орших Улаанбаатар хотын уур амьсгал нь манай орны уур амьсгалын эх газарлаг шинж чанарыг бүрэн илэрхийлэх эрс тэс шинжтэй. Өөрөөр хэлбэл сэрүүн бүсийн эх газрын уур амьсгалын эрс тэс эх газарлаг шинж чанарыг илэрхийлсэн тодорхой ялгарсан жилийн дөрвөн улиралтай, өвөл нь хүйтэн, үнэмлэхүй бага температур нь -38.30°C хүрдэг, үнэмлэхүй их температур нь 36.90°C хүрдэг, үнэмлэхүй их бага температурын агууриг нь (75.20°C) эрс тэс ялгаатай. Жилийн дундаж температур нь 0.40°C , хамгийн хүйтэн I сарын дундаж температур -21.3°C бол хамгийн дулаан сар болох VII сарын дундаж температур 19.50°C байдаг байна. Улаанбаатар хотод жилд дунджаар 257.1 мм хур тунадас ордог. Хур тунадасны жилийн явцыг авч үзэхэд зуны улиралд 173.1 мм буюу жилийн нийлбэр хур тунадасны 89 орчим хувь нь унадаг бол үлдсэн хувь нь зунаас бусад улирлуудад унадаг байна. Салхины зонхилох чиглэлийн хувьд манай ерөнхий зонхилох чиглэл илэрдэг бөгөөд баруунаас нийт салхины чиглэлийн 22.1% баруун хойноос, хойноос 20% , баруунаас 13.5% давтагдалтай байдаг. Салхины хурдны олон жилийн дундаж нь төдий л ихгүй ойролцоогоор 2.1 м/с байдаг. Салхины хурдны жилийн явцаас авч үзвэл 4, 5 дугаар сард хамгийн их, харин хүйтний улиралд манай улсын нутагт төвтэй эсрэг циклон оршдог тул салхины хурд багасдаг байна.

2.3. АГААРЫН ЧАНАР

Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 15 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2), $\text{PM}_{2.5}$, PM_{10} тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O_3)-ы агууламжийг автомат багаж болон химийн аргаар тодорхойлж байна. Төслийн талбай орчмын бүс нутгийн агаарын чанарын өнөөгийн төлөв байдлыг төслийн талбайн газар нутагт 2022 оны 4-р сарын 07-ны өдөр нийт 5 цэгт агаар дахь түгээмэл бохирдуулагч болох хүхэрлэг хий, азотын давхар исэл, тоосжилтын сорьц авч шинжилгээг хийснээс гадна дуу шуугианы түвшний хэмжилт хийн Цаг уур орчны шинжилгээний газрын Байгаль орчин хэмжилзүйн төв лабораториор шинжлүүлсэн бөгөөд тус судалгааны үр дүн болон төслийн талбайд хамгийн ойр орших Цаг уурын орчны шинжилгээний газрын агаарын чанарыг хянах Толгойт суурин автомат харуулын 2015-2021 оны сар бүрийн хэмжилтийн мэдээг үндэслэн

тодорхойлов. Агаарын чанарыг хянах Толгойт харуул нь Сонгинохайрхан дүүрэг, 3-р хороо, 65-р сургууль орчим зүүн уртрагийн 106084'75", хойд өргөргийн 47091'96" байршилд байрлана.

2.4. ГЕОЛОГИЙН ТОГТОЦ:

2004-2005 оны геозкологийн региональ судалгаанд хамрагдсан Улаанбаатар хотын дэвсгэр талбайд болон зэргэлдээх зарим дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд геологийн тогтцын хувьд доод-дунд девон, доод-дунд карбоны настай тунамал-бялхмал-хувирмал чулуулгийн зузаалаг, дээд триас-доод юрийн настай гүний шургамал чулуулаг, доод цэрд, неогены плиоцены үеийн шаварлаг, түүнчилэн дөрөвдөгчийн сэвсгэр хурдас зонхилон тархжээ. Иймд тухайн бүс нутгийн геологийн тогтцын дээр дурдсан өвөрмөц онцлогийг үндэслэн, 2004-2005 онд явуулсан геозкологийн региональ судалгааны талбайд тархсан нийт насны хурдас, чулуулгийг дараах давхарга зүйн ангилалд хамааруулж байна. Үүнд:

- Доод-дунд девоны настай тунамал-бялхмал-хувирмал чулуулгийн зузаалаг (D₁₋₂)
- Доод-дунд карбоны настай тунамал-хувирмал чулуулгийн зузаалаг (C₁₋₂)
- Дээд триас-доод юрийн настай гүний шургамал чулуулгийн массив (T₃-J₁)
- Доод цэрдийн настай тунамал хурдасны зузаалаг (K₁)
- Неогены плиоцены үеийн шаварлаг хурдасны зузаалаг (N₂)
- Дөрөвдөгчийн сэвсгэр хурдас / Q /

2.5. ГАДАРГЫН УСНЫ БҮРЭЛДЭХ ОНЦЛОГ

Улаанбаатар хотын дэвсгэр талбай болон зэргэлдээх зарим дүүргийн бүс нутаг нь газар зүйн байршлын хувьд ойт хээрийн бүсэд 1950-2265 м үнэмлэхүй өндөртэй Богдхан, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх зэрэг өндөр уулсын муж, түүнчлэн Туул голын ай сав, түүний хажуу жигүүрийн жижиг цутгал голуудын хөндийн хэмжээнд багтаж байрладаг. Улаанбаатар хотын ихэнх барилга байгууламж нь Туул голын хөндийн ай сав болон Сэлбэ голын адаг хэсэгт тархан байрласнаас гадна Зүүн, Баруун Наран, Цагаан хуарангийн дэнжид гол барилга, байгууламж тархжээ. Түүнчлэн Туул голын хөндийн өмнөд жигүүрт Их, Бага тэнгэрийн аманд төр, засгийн тусгай объектууд тодорхой хамгаалалтын бүсэд оршдог. Үүний зэрэгцээ Сэлбэ, Хөл, Бэлхийн голын хөндий, Туул голын Дээд Хар Усан тохой, Могойн дэнж, Их Хуанди, Улиастай, Гачууртын голын адаг, Толгойтын голын Зүүн, Баруун салаа орчмоор хувийн сууцны зориулалттай бэсрэг цогцолбор, зуслангийн барилга байгууламж, гэр хорооллын объектууд нэлээд шигүү хэлбэрээр байрлаж байна.

Сонгинохайрхан дүүргийн 1,2,3,20,34,35 -р хорооны хэрэгжүүлэхээр төлөвлөж буй "Толгойт дэд төв барих" төслийн талбай орших бүс нутаг нь ус зүйн хувьд дэлхийн ус хагалбарын Хойд мөсөн далайн ай савд, Монгол орны Туул голын сав газарт багтана. Энэ бүс нутагт байгалийн тогтоц, уур амьсгалын нөхцөлөөс хамааран гадаргын усан сүлжээ харьцангуй сайн хөгжсөн. Төслийн талбайд ойролцоо орших гадаргын усан сүлжээ нь Улиастай, Туул голууд бөгөөд төслийн талбайд хамгийн ойрхон нь 500м зайтай Сэлбэ гол болон Тахилтын гол юм.

2.6. ГИДРОГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ

Судалгаанд хамрагдсан дэвсгэр талбайн хэмжээнд тухайн бүс нутгийн шинж төрхтэй гидрогеологийн нөхцөлийг илэрхийлж буй газрын доорх усны тархалт, бүрэлдэн тогтолтын байгалийн ерөнхий зүй тогтолт болон геологийн тогтцын суурь нөхцөлийн өвөрмөц онцлогийг үндэслэн, гидрогеологийн давхарга зүйчлэлийн хувьд дараах уст үе давхарга, цогцолбор, газрын доорх усны бусад хуримтлал, бөөгнөрлийг ялгаж байна Үүнд:

- Голоцены үеийн аллювийн гарал үүсэлтэй сэвсгэр хурдасны уст давхарга (aIQ2)
- Дунд-дээд плейстоцений үеийн делюви-пролювийн гарал үүсэлтэй сэвсгэр хурдасны

уст давхарга (dpQ1-2)


- Доод-дунд карбоны настай тунамал-хувирмал чулуулгийн зузаалаг дахь уст цогцолбор (C 1-2) зэрэг болно.

2.7. ХӨРСӨН БҮРХЭВЧИЙН ОНЦЛОГ, ТАРХАЛТ

“Толгойт дэд төв барих” төслийн талбай орших Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 1,2,3, 20-р хорооны нутагт суурьшлын бүсэд байрлана. Энэ орчмын нутаг дэвсгэр Хөрс-газарзүйн мужлалаар Төв Азийн их мужийн Хангайн мужийн өндрийн бүсчлэлийн Хангай-Хэнтийн дэд мужийн өмнөдийн 53-р тойрогт хамрагдана. Төслийн талбай нь Хөрсний газарзүйн мужлалаар Улаанбаатар хот хөрс-био уур амьсгалын Хангайн их мужийн Хэнтийн өмнөх тойрогт багтах бөгөөд Туул голын өргөн хөндий, Хэнтийн нурууны салбар уулын энгэр хажуугаар ихэвчлэн хар хүрэн хөрс зонхилно. Төслийн талбайн далайн түвшнээс дээш 1230 м өндөрт оршино. Энд Тал хөндийн хар хүрэн хөрс болон Аллювийн үйрмэг чулуутай хөнгөн шавранцар хөрс байна. Хөрс үүсгэгч эх чулуулаг нь делювийн хурдас чулуулаг байна.

2.8. УРГАМЛЫН НӨМРӨГ

Толгойт дэд төв барих” төслийн талбай Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 1,2,3,20-р хорооны нутаг дэвсгэрт орших “Толгойт болон Орбит орчим хэрэгжинэ. Төсөл хэрэгжих газар орших бүс нутаг нь ургамал газарзүйн ангиллаар Хэнтийн уулын тайгын тойрогт оршино.



Зураг 3. Монгол орны ургамал газарзүйн тойрог


Тус газрын ургамлын зүйлийн бүрдэл нь 6 овгийн 11 зүйл ургамал бүртгэгдлээ. Олон нас ургамлын дийлэнхийг үетэн эзэлж байгаа бөгөөд цөөн наст хөл газрын ургамлууд зүйлийн бүрдлийн талаас илүү хувийг эзэлж байна.

2.9. АМЬТНЫ АЙМАГ

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 1,2,3,20,34,35-р хороонд хэрэгжих “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” –ийн “Толгойт дэд төв” нь Монгол орны хөхтөн амьтдын газарзүйн мужлал (Банников, 1954)–аар Хээрийн ба ойт хээрийн дэд мужийн Хэнтийн тойрогт багтах бөгөөд Нийслэлийн хотын суурьшлын бүс нутагт оршиж байна. Улаанбаатар хот орчмын газар нутаг нь Монгол орны хөхтөн амьтдын газарзүйн мужлал (Банников, 1954)–аар Хойд доод муж, тайгын провинци, Хэнтийн тойрогт багтана. Нийслэлийн ногоон бүсийн хөхтөн амьтдын төлөв байдлын судалгаанд нийт 93.6 мянган га талбай бүхий Гачуурт, Шар хоолой, Хуандай, Дээндийн амнууд, Санзайн ам зэрэг ой бүхий томоохон ам хөндий хамрагджээ.

2.10. ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГ

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 1,2,3,20,34,35-р хорооны нутаг дэвсгэрт орших “Толгойт дэд төв барих төслийн талбай нь улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газартай давхцахгүй юм. Тус төслийн талбайгаас улсын тусгай хамгаалалттай Богдхан уулын ДЦГ урд зүгт 5.5 км, Чингэлтэй уулын БНГ-ын 2-р хэсэг хойд зүгт 17.6 км, дүүргийн тусгай хамгаалалттай Бурхантын хэмээх газар баруун хойд зүгт 18.1 км, Сонгинохайрхан уулын тусгай хамгаалалттай газар баруун урд зүгт 1.5 км зайтай оршдог байна




Зураг 4. Төслийн талбай, түүний орчмын УТХГН ба ОНТХГН-ууд

2.11. НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ.

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 10 сарын 21 ний а/1228 дугаар тогтоолоор Шархад, Толгойт дэд төвүүдийн техник эдийн засгийн үндэслэлийг баталсан.

Толгойт дэд төв нь Сүхбаатарын талбайгаас 12км, хамгийн ойр байрлах Баянхошуу дэд төвөөс 4 км зайд байршилтай. Энэхүү бүс нь баруун хэсгийн хотын алслагдсан бүс юм.

Толгойт дэд төвийн газар нутагт нийт 551,4 га газар харьяалагдах ба Сонгинохайрхан дүүргийн 1, 2,3, 20, 35 дугаар хороод багтдаг. Толгойт дэд төв нь хойд хэсгээрээ уул толгодоор, урд хэсгээрээ төмөр замаар хүрээлэгдсэн. Зүүн урд талаараа орон сууцны хороолол барихаар байршлын тогтолцоотой боловч дэд төвийн хил орчмын эргэн тойрны ихэнх газарт гэр хороолол байдаг. Энэхүү дэд төв нь 40 га газар бүхий Харилцаа холбооны төв, 30 га газар бүхий цэргийн баазтай. Мөн төмөр замтай холбогдсон тул зүүн хэсгээрээ хэд хэдэн томоохон хэмжээний түгээлтийн төвтэй ба нутаг дэвсгэр нь төмөр замын хэвтээ шугамын дагуу хуваагддаг. Толгойт төвийн эдийн засгийн үйл ажиллагаа нь тухайн бүсийн хэмжээний худалдааны төвүүд, жижиг хэмжээний үйлдвэрлэл эрхлэгчдээр хязгаарлагддаг бөгөөд авто замын уулзварууд дагасан жижиг дэлгүүрүүд мөн үйл ажиллагаа явуулдаг



Зураг 5. Толгойт дэд төвийн байршил, засаг захиргааны хил хязгаар

3. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ БОЛОН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1. Газрын гадаргад нөлөөлөх нөлөөлөл

Газрын гадаргын эвдрэл: Толгойт дэд төвд зам, цэвэр бохир ус, дулаан, холбоо, цахилгааны шугам сүлжээ ба сургалтын төв, Эрүүл мэндийн төв байгуулах ажлын үед талбайн тэгшилгээ болон нүх шуудуу, барилгын суурь ухах явцад газрын хэвлий, хөрсний чанараас шалтгаалж 0.3-5 метр хүртэл газрын хэвлийг хөндөх ба нийт 17.32 га талбайн газрын гадарга нөлөөлөлд өртөнө.



Зураг 6. Төслийн нөлөөлөл

Хаягдал шороон материал үүсэх: Сургалтын төв, инженерийн шугам хоолой тавих шуудуу ухах, гадна зам талбайн цэвэрлэгээ, тэгшилгээний ажлуудаас нийт 109,159.81м³ шороон материал үүсэж, үүнээс 87216.51 м³ шороог шугам хоолой тавих шуудууны нөхөн дүүргэлтэд ашиглаж, үлдсэн 21943.30 м³ хаягдал шороон материалыг зөвшөөрөгдсөн цэгт хүргэж зайлуулна. Газар шорооны ажлаас үүсэх шорооны материалын тооцооллыг Хүснэгт 5-д үзүүлэв.

Гадаргын төрх байдал өөрчлөгдөх: Барилгын ажлын үед барилгын суурь, шугам хоолой татах нүх шуудуу ухах, хөрсний овоолго үүсэх зэргээр гадаргын төрх байдалд түр хугацааны өөрчлөлтүүд орно. Төслийг хэрэгжүүлэх явцад буюу барилгын ажлын явцад бий болох дээр дурдсан нөлөөллүүд нь зайлшгүй тохиолдох, түр зуурын шинж чанартай байх бөгөөд багавтар хэмжээний талбайг хамрах ч дэд бүтцийн шугамуудын нийт урт нь цахилгаан шугам 90км бол бусад шугам хоолой 51.1 км үргэлжлэх тул нөлөөллийн тархалт нь дунд зэрэг байна. Барилгын ажил дуусах үед үүссэн нүх, шуудууг нөхөн дүүргэж, орчны зам талбайд нөхөн сэргээлт хийн ургамалжуулах ба нөлөөллийн эрчим нь дунд зэрэг байх болно. Шинээр баригдах нийгмийн барилга байгууламжуудын ашиглалтын үе шатанд газрын гадарга болон хэвлийд шууд нөлөөлөл үзүүлэхгүй. Төслийн хүрээнд явагдах барилгын багц ажлуудаас үүсэх газрын гадаргын эвдрэл, газар шорооны ажлын тооцоог Хүснэгт 5-д нэгтгэн үзүүлэв.

2025 онд хэрэгжүүлэх Толгойт дэд төвийн Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөө, Орчны Хяналт Шинжилгээний Хөтөлбөр

Хүснэгт 5. Толгойт ДТ-ийн газар шорооны ажлын шорооны материалын тооцоолол.

Гэрээний дугаар	Дэд бүтцийн ажлууд	Ажлын тоо хэмжээ	Ухагдах гүн /метр/	Газар шорооны ажлын хэмжээ м ³	Хоолойн хамгаалалтын хавтан эзлэх талбай	Буцааж дүүргэх газар шорооны ажлын хэмжээ м ³
ТЕС-А	Толгойт дэд төвд цахилгаан холбоо, шугам сүлжээ	Холбооны шугам: урт 7.14 км, диаметр: 110мм, байр төв 925м ² болон 272м ² - 2ш Нөлөөлөлд өртөх талбай: 4,767м ²	0,5-1.0 метрийн гүнтэй ухалт хийгдэнэ. Өргөн 0.5 метр	Холбооны шугам: 2,383.5м ³	Өргөн 0.3метр Өндөр 30см, Урт: 4 метр Холбооны шугамын хавтан: 642.6 м ³	Холбооны шугам: 2,383.5м ³ -642.6 м ³ = 1,740.9 м ³
ТЕС-В	Толгойт дэд төвд цахилгааны дэд станц, 10кВ цахилгаан түгээх кабель шугам	10/0.4кВ хүчин чадалтай хаалттай дэд станц (ХТП)-1 РП, кабель шугам 47500м Нөлөөлөлд өртөх талбай: 24,850 м ²	0.5-1.0 метрийн гүнтэй ухалт хийгдэнэ.	23,750	Өргөн 0.3метр Өндөр 30см, Урт: 4 метр . Хавтан: 4,275 м ³	Цахилгааны кабель шугам: 23,750м ³ -4,275 м ³ = 19,475м ³
ТЕС-С	Толгойт дэд төвийн цахилгаан түгээх байгууламж, 10кВ цахилгаан түгээх кабель шугам	Цахилгааны кабель шугам: урт= 42500 м, удирдлагын байр 140м ² Нөлөөлөлд өртөх талбай: 21,390м ²	0,5-1 метрийн гүнтэй ухалт хийгдэнэ.	Цахилгааны кабель шугам: 10,695м	Өргөн 0.3метр Өндөр 30см, Урт: 4 метр . Хавтан: 3,825 м ³	Цахилгааны кабель шугам: 10,695м ³ -3,825 м ³ = 6,870м ³
TRDH11A	Авто замын зогсоол	Автомашины зогсоол: НЭТ-3-д 7618.7м ² талбай Нөлөөлөлд өртөх талбай: 7618.7м ²	Газар чөлөөлөлтийн талбайгаас хамаарч 0.3 0.5 метр хүртэл ухалт хийгдэнэ	Толгойт орчмын далан болон замын налуугаас шалтгаалж 2,285.4м ³ ул хөрсний ажил хийгдэнэ.	-	Буцааж дүүргэх хөрс шороо байхгүй бүгдийн зайлуулна. Замын хөрсний шаардлага хангахгүй.
	Бохир усны шугам сүлжээ	Бохирын шугам: Ф200~300мм, урт= 947 м Нөлөөлөлд өртөх талбай: 757.6м ²	3.0-5.0 метрийн гүнтэй ухалт хийгдэнэ. Өргөн 0.8 метр	Ариутгах татуурга: 2,272.8м ³	Өргөн 0.6метр Өндөр 70см, Урт: 4 метр Бохир шугамын хавтан: 397.74м	Ариутгах татуурга: 2,272.8м ³ - 397.74м ³ = 1,875.06м ³
	Дэд өртөө КТПН 63кВА	Барилга Нөлөөлөлд өртөх талбай: 1200 м ²	0.5 метрийн гүнтэй ухалт хийгдэнэ.	600м ³	Өргөн 0.6метр Урт: 140 метр	600-84=516м ³
TRDH11B	Авто зам А4 авто зам	Урт: 1461 м, өргөн: 7 м, явган хүн 4 м. нийт 11метр Нөлөөлөлд өртөх талбай: 16,071 м ²	Газар чөлөөлөлтийн талбайгаас хамаарч 0.3 0.5 метр хүртэл ухалт хийгдэнэ	8,035.5м ³ ул хөрсний ажил хийгдэнэ.	-	Буцааж дүүргэх хөрс шороо байхгүй бүгдийн зайлуулна. Замын хөрсний шаардлага хангахгүй.
	Автомашины зогсоол	Нөлөөлөлд өртөх талбай: 599,3м ² м ²		179.79м ³ ул хөрсний ажил хийгдэнэ.	-	
TRDH11C	Усан хангамжийн сүлжээ	шугам Урт= 2890м, диаметр (Ф200~300мм) Нөлөөлөлд өртөх талбай: 2,312 м ²	3.0-5.0 метрийн гүнтэй ухалт хийгдэнэ. Өргөн 0.8 метр	Цэвэр усны шугам 6,936 м ³	Өргөн 0.6метр Өндөр 70см, Урт: 4 метр Дулаан хангамжийн хавтан: 1,213.8 м ³	Цэвэр усны шугам 6,936 м ³ - 1,213.8 м ³ = 5,722.2 м ³

2025 онд хэрэгжүүлэх Толгойт дэд төвийн Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөө, Орчны Хяналт Шинжилгээний Хөтөлбөр

	насос станц Q=4600м ³ /х	Барилга Нөлөөлөлд өртөх талбай: 2000 м ²	0.5 метрийн гүнтэй ухалт хийгдэнэ.	1000м ³	Өргөн 0.6метр Урт: 200 метр	1000-120=880м ³
TRDH14A	A2.A5 хэмжээтэй авто зам, замын байгууламж	Урт: 1,613.9м, өргөн: 7 м, явган хүн 4 м. нийт 11метр Нөлөөлөлд өртөх талбай: 11,297.3м ²	0.3-0.5 метр хүртэл ухалт хийгдэнэ	3,389.19 м ³ ул хөрсний ажил хийгдэнэ.	-	Буцааж дүүргэх хөрс шороо байхгүй бүгдийн зайлуулна.
	Гадна дулааны шугам сүлжээ Салбар-2	Дулааны шугам Урт= 1254 м, диаметр (Ф200~300мм) Нөлөөлөлд өртөх талбай: 1,003.2м ²	3.0-5.0 метрийн гүнтэй ухалт хийгдэнэ. Өргөн 0.8 метр	Дулаан хангамж: 3,009.6м ³	Өргөн 0.6метр Өндөр 70см, Урт: 4 метр Дулаан хангамжийн хавтан: 526.68м ³	Дулаан хангамж: 3,009.6м ³ - 526.68м ³ = 2,482.92м ³
	Авто зогсоол	Нөлөөлөлд өртөх талбай: 516м ²	Газар чөлөөлөлтийн талбайгаас хамаарч 0.3 0.5 метр хүртэл ухалт хийгдэнэ	258 м ³ ул хөрсний ажил хийгдэнэ.	-	Буцааж дүүргэх хөрс шороо байхгүй бүгдийн зайлуулна.
	Усан хангамжийн сүлжээ	шугам Урт= 966.8м, диаметр (Ф200~300мм) Нөлөөлөлд өртөх талбай: 773.44м ²	3.0-5.0 метрийн гүнтэй ухалт хийгдэнэ. Өргөн 0.8 метр	Цэвэр усны шугам 2,320.32 м ³	Өргөн 0.6метр Өндөр 70см, Урт: 4 метр Дулаан хангамжийн хавтан: 406.056м ³	Цэвэр усны шугам 2,320.32 м ³ - 406.056м ³ = 1,914.264 м
	УДДТ 2, 3, 4 / 3 ширхэг	Нөлөөлөлд өртөх талбай: 216*3= 648 м ²	0.5 метрийн гүнтэй ухалт хийгдэнэ.	624м ³	Өргөн 0.6метр Урт: 60 метр	324-36=288м ³
TRDH14B	A3хэмжээтэй авто зам, замын байгууламж	Урт: 460м, өргөн: 7м, явган хүн 4 м. нийт 11метр Нөлөөлөлд өртөх талбай: 5,060м ²	0.3-0.5 метр хүртэл ухалт хийгдэнэ	2,530м ³ ул хөрсний ажил хийгдэнэ.	-	Замын хөрсний шаардлага хангахгүй.
	Усан хангамжийн сүлжээ	шугам Урт= 1930м, диаметр (Ф200~300мм) Нөлөөлөлд өртөх талбай: 1,544 м ²	3.0-5.0 метрийн гүнтэй ухалт хийгдэнэ. Өргөн 0.8 метр	Цэвэр усны шугам 4,632 м ³	Өргөн 0.6метр Өндөр 70см, Урт: 4 метр Дулаан хангамжийн хавтан: 810.6м ³	Цэвэр усны шугам 4,632 м ³ - 810.6м ³ = 3,821.4 м ³
	Бохир усны шугам сүлжээ	Бохирын шугам: Ф200~300мм, урт= 1076 м Нөлөөлөлд өртөх талбай: 860.8 м ²	3.0-5.0 метрийн гүнтэй ухалт хийгдэнэ. Өргөн 0.8 метр	Ариутгах татуурга: 2,582.4 м ³	Өргөн 0.6метр Өндөр 70см, Урт: 4 метр Бохир шугамын хавтан: 451.92м ³	Ариутгах татуурга: 2,582.4 м ³ - 451.92м ³ = 2,130.48 м ³
	Төвлөрсөн дулааны шугам сүлжээ	Дулааны шугам Урт= 1338.5 м, диаметр (Ф200~300мм) Нөлөөлөлд өртөх талбай: 1,070.8 м ²	3.0-5.0 метрийн гүнтэй ухалт хийгдэнэ. Өргөн 0.8 метр	Дулаан хангамж: 3,212.4 м ³	Өргөн 0.6метр Өндөр 70см, Урт: 4 метр Дулаан хангамжийн хавтан: 562.17м ³	Дулаан хангамж: 3,212.4м ³ - 562.17м ³ = 2,650.23 м ³
	УДДТ 1, 5	Нөлөөлөлд өртөх талбай:	0.5 метрийн гүнтэй ухалт	216м ³	Өргөн 0.6метр Урт: 40	216-24=192м ³

2025 онд хэрэгжүүлэх Толгойт дэд төвийн Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөө, Орчны Хяналт Шинжилгээний Хөтөлбөр

		216*2=432 м ²	хийгдэнэ.		метр	
SHTL-(C1-C5)	Толгойтын дэд төвүүдийн ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн талбай-1,2,3,4	700	Газар чөлөөлөлтийн талбайгаас хамаарч 0.3 0.5 метр хүртэл ухалт хийгдэнэ	350м ³	-	Буцааж дүүргэх хөрс шороо байхгүй бүгдийн зайлуулна.
SHTL-D		700		350 м ³	-	
TFP-A	Толгойт дэд төвд (Баруун наран) үерийн хамгаалалт, ус зайлуулах хоолой	Үерийн суваг: урт 3,554 м, өргөн 1-1.5 м Нөлөөлөлд өртөх талбай: 5,331м ²	0.5-1.0 метрийн гүнтэй налуужуулалт хийнэ.	Үерийн суваг хийх: 2,665м ³	-	-
SHTSC-A	Толгойтын ус, бохир ус, дулааны хоёрдогч холболт (Цэргийн хотхон)	Ф530х8мм-ийн голчтой 1.3 км дулааны шугамын угсралтын ажил Нөлөөлөлд өртөх талбай: 1,040м ²	3.0-5.0 метрийн гүнтэй ухалт хийгдэнэ. Өргөн 0.8 метр	Дулаан хангамж: 3,120 м ³	Өргөн 0.6метр Өндөр 70см, Урт: 4 метр Дулаан хангамжийн хавтан: 546м ³	Дулаан хангамж: 3,120м ³ - 546м ³ = 2,574м ³
SHTSC-B	Баянхошуу дэд төв(Оргил)-ийн цэвэр, бохир ус, халуун ус, дулаан түгээх шугам сүлжээний нийлүүлэлт, суурилуулалт	Ариутгах татуургын шугам - 3км Гадна цэвэр усны шугам - 1,6км Дулаан хангамжийн шугам - 2км УДДТ-2ш Нөлөөлөлд өртөх талбай: 2,835м ²	3.0-5.0 метрийн гүнтэй ухалт хийгдэнэ. Өргөн 0.8 метр	Ариутгах татуурга: 7200 м ³	Өргөн 0.6метр Өндөр 70см, Урт: 4 метр Бохир шугамын хавтан: 1,260м ³	Ариутгах татуурга: 7200 м ³ - 1,260м ³ = 5,740м ³
				Цэвэр усны шугам 1,280м ³	Өргөн 0.6метр Өндөр 70см, Урт: 4 метр Дулаан хангамжийн хавтан: 364м ³	Цэвэр усны шугам 1,280м ³ - 364м ³ = 916 м ³
				Дулаан хангамж: 4,800м	Өргөн 0.6метр Өндөр 70см, Урт: 4 метр Дулаан хангамжийн хавтан: 840 м ³	Дулаан хангамж: 4,800м ³ - 840 м ³ = 3,960м ³
				Нөлөөлөлд өртөх талбай: 216*2=432 м ²	0.5 метрийн гүнтэй ухалт хийгдэнэ.	216м ³
TSC+SHTL-A	Толгойт дэд төвийн дунд сургууль. 320 суудалтай	Нөлөөлөлд өртөх талбай: 3722.21 м ²	1.0 метрийн гүнтэй ухалт хийгдэнэ.	3722.21 м ³ /90% буцаан дүүргэлт хийнэ/		3,350
		2433.6м ²	Газар чөлөөлөлтийн талбайгаас хамаарч 0.3 0.5 метр хүртэл ухалт хийгдэнэ	1,216.8м ³ .	-	Буцааж дүүргэх хөрс шороо байхгүй бүгдийн зайлуулна.
TBC	Сургалтын төв	Нөлөөлөлд өртөх талбай: 2081 м ² талбай	Хагас зоорины хэсэг 1.6 метрийн гүнтэй ухалт хийгдэнэ.	3,329.6м ³ /40% буцаан дүүргэлт хийнэ/		1,331.84

Хүснэгт 6. Нөлөөллийн бүс

Нөлөөллийн хэмжээ	Талбай /га/
Их	34
Дунд	120
Бага	264
Нөлөөллийн бүс: 418га	

Хүснэгт 7. Экосистемийн ангилал

Нөлөөллийн ангилал	Экосистемийн ангилал					
	Өвөрмөц (3)		Ховор (1.5)		Нийтлэг (0.2)	
	Бодит (га)	Нөлөөллийн нэгж	Бодит (га)	Нөлөөллийн нэгж	Бодит (га)	Нөлөөллийн нэгж
Их (1)	0	0	0	0	34.98	7
Дунд (0.66)	1.0	2	0	0	119.03	16
Бага (0.33)	4.25	4	0	0	260.66	17
Нийт офсет нэгж = 46						

Хүснэгт 8. Амьдрах орчны төрөл

Нөлөөллийн ангилал	Амьдрах орчны төрөл					
	Энгийн (3)		Байгалийн (1.5)		Өөрчлөгдсөн (0.2)	
	Бодит (га)	Нөлөөллийн нэгж	Бодит (га)	Нөлөөллийн нэгж	Бодит (га)	Нөлөөллийн нэгж
Их (1)	0	0	0	0	34.98	7
Дунд (0.66)	0	0	0	0	120.03	16
Бага (0.33)	0	0	0	0	264.91	17
Нийт офсет нэгж = 40						

Хүснэгт 9. Ландшафтын нөхцөл

Нөлөөллийн ангилал	Ландшафтын нөхцөл					
	Сайн(3)		Дунд зэрэг (1.5)		Муу (0.2)	
	Бодит (га)	Нөлөөллийн нэгж	Бодит (га)	Нөлөөллийн нэгж	Бодит (га)	Нөлөөллийн нэгж
Их (1)	0	0	0	0	34.98	7
Дунд (0.66)	0	0	0	0	119.03	16
Бага (0.33)	0	0	0	0	260.66	17
Нийт офсет нэгж = 40						

Хүснэгт 10. Газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ.

№	Сөрөг нөлөөлөл	Хэлбэр		Нөлөөллийн зэрэг				Нөлөөллийн үргэлжлэх хугацаа				
		Шууд	Дам	Маш бага	Бага	Дунд	Их	Аюултай	Түр зуурын	Богино хугацааны	Дунд хугацааны	Урт хугацааны
Гол сөрөг нөлөөлөл												
1	Газар шорооны ажлаас нийт18.886га талбайн газрын гадарга эвдрэлд өртөнө								+			
2	Газар шорооны ажлаас нийт 134,352м ³ хаягдал шороон материал үүснэ									+		
3	Гадаргын төрх байдалд түр хугацааны өөрчлөлт орно											
Нөлөөллийн тоо		-	-	-	-	3	-	-	2	1	-	-
Нөлөөллийн хувь %		-	-	-	-	100	-	-	67	33	-	-
Дүгнэлт: Төслийн нийт хугацаанд газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөллүүдийг тодорхойлж,												

тус бүрт нь үнэлгээ өглөө. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хэвлийд үзүүлэх нийт сөрөг нөлөөлөл нь 100% нь дунд зэргийн эрчимтэй байна. Төслийн үйл ажиллагаанаас үзүүлж байгаа нөлөөллүүд нь үргэлжлэх хугацааны хувьд 67% түр зуурын, 33% нь богино хугацааны нөлөөлөл байна. Төслийн хэрэгжилтийн явцад нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд, тэдгээрийн үр дүнг хянах хяналт шинжилгээний хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж чадвал төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөллийг бууруулах бүрэн боломжтой гэж дүгнэв.

3.2. АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Гол сөрөг нөлөөлөл

Тоосжилт: Төслийн барилгын ажлын үе шатанд хөрс хуулалт, газар шорооны ажил, барилгын материал тээвэрлэх хүнд даацын машин техникийн нөлөөллөөр агаар орчинд тоосжилт үүсэж, нарийн ширхэгт тоосонцрын агууламж нэмэгдэх хандлагатай байна.

Тус төслийн хүрээнд Авто зам 4 эгнээ бүхий зам 1.97 км, 2 эгнээ бүхий зам 4.067км, дугуйн зам 5.9 км, Дулаан хангамжийн 6.728 км, Ариутгах татуургын 12.094 км шугам, цэвэр усны 7.38 км шугам, цахилгааны кабелийн 90.0 км шугам, холбооны 7.1 км шугам сүлжээ татах, Сургалтын төв, Эрүүл мэндийн төв барих, 5.375 км үерийн суваг тохижуулах зэрэг ажлаас нийт 17.32 га талбайн хөрсийг хүнд машин механизмаар ухах, ачих, тээвэрлэх явцад тухайн орчинд тоосжилт үүснэ. Барилга барих ажлын горимоос хамаараад газар шорооны ажил нийт төслийн хэмжээнд 1-2 жилийн хугацаанд, харин тухайн барилгын ажлын цэг дээр 120 хүртэлх хоногийн турш үргэлжилнэ. Агаарын тоосны бохирдол нэг удаагийн хамгийн их хэмжээ 0.5 г/м³ –аас их бол хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж эхэлдэг. Барилгын ажлын норм дүрэмд үндэслэн тооцвол төслийн барилгын ажилд хамгийн багадаа дараах тооны машины техникүүд ашиглагдана. Үүнд

- Авто зам: 1-2 экскаватор, 10-15 самосвал, 3-4 ковш, 1-2 грейдер, 4-5 индүү, 1-2 усны машин ажиллана
- Инженерийн шугам хоолой тавих, салбар шугамын холболт хийх: 6-8 экскаватор, 10 15 самосвал, 5-6 ковш, 2-3 кран, 2-3 шугам тээвэрлэх шланз
- Цахилгаан: 1-2 өрмийн машин, 1 экскаватор, 1-2 самосвал, 1 ковш, 1 материал тээвэрлэх шланз
- ОНХТ барилга байгууламж: 1-2 экскаватор, 2-3 самосвал, 2 ковш, 1 кран, 1-2 материал тээвэрлэх шланз

Төслийн хүрээнд ажиллах машин механизмын тоог нэгтгэн авч үзвэл 9-13 экскаватор, 26 40 самосвал, 8-11 ковш, 4-6 кран, 1-2 грейдер, 4-5 индүү, 1-2 усны машин, 4-6 материал тээвэрлэх шланз гэх мэт нийт 30-50 тооны машин механизм ажиллах бөгөөд нэг машин механизм цагт 20-25 л түлш зарцуулна.

Агаар мандалд учруулсан хохирлыг дараах томъёогоор тооцно.

$$\text{Уг} = \text{Таг} * \text{G} * \text{f} * \text{Ma, төг}$$


Газар шорооны ажлын үед машин техникийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт: “Толгойт дэд төв барих төсөл”-ийн нийт эвдрэлд өртөх талбайн хэмжээ 13.859 га болно. Уг талбайгаас үүсэх тоосжилтыг дээрх томъёогоор тооцвол: $\text{П} = 199,841.74\text{м}^2 * 0.1.10^{-6} \text{ кг}/(\text{м}^2/\text{с}) * 0.1 = 0.00199841 \text{ кг}/\text{сек}$ буюу цагт 7.19кг/цаг байна. Энэ нь газар шорооны ажлын үед буюу өдөрт 12 цаг нийт 60 хоногийн хугацаанд 5,179.8кг/жил тоос дэгдэхээр байна. Үүнийг үе шат тус бүрээр авч үзэв.

Хүснэгт 11. Багц тус бүрээс гарах тоосжилтын хэмжээ.

Гэрээний дугаар	Ажлын тоо хэмжээ м²	Нэгж талбайгаас гарах тоосжилт	Гарах тоосжилтын хэмжээ кг/жил
ТЕС-А	4,767	0.025899 кг/жил	123.46
ТЕС-В	24,850		643.59

TEC-C	21,390		553.98
TRDH11A	9,576.3		248.01
TRDH11B	16,670.3		431.74
TRDH11C	4,312		111.6
TRDH14A	14,237.94		368.7
TRDH14B	8,967.6		232.25
SHTL-(C1-C5)	700		18.13
SHTL-D	700		18.13
SHTSC-A	1,040		26.94
SHTSC-B	3,267		84.61
TFP-A	5,331		138.06
TBC	2081		53.89
TSC+SHTL-A	6155.81		159.43
	124,046м ² буюу 12.4га		3212.52

Барилгын үйл ажиллагаанаас үүсэх бохирдлын тархалт: Замын барилгын ажлаас үүсэх тоос тоосонцор. Замын барилгын ажлын үед хийгдэх газар шорооны ажлаас үүдэлтэй тоос тоосонцрын хэмжээг Европын холбооны хүрээлэн буй орчны агентлагаас гаргасан аргачлалын дагуу тооцсон. Замын ажил нь хэсэгчилсэн байдлаар явагдах ба тоос тоосонцрын тархалт нь үйл ажиллагаа явж буй талбайгаас 300 м хүртэлх зайд орчны агаар дахь PM₁₀ тоосонцрын хоногийн дундаж агууламжийг 50 200мкг/м³ хэмжээгээр нэмэгдүүлэхээр байна. Замын барилгын ажил нь богино хугацаанд хийгдэх тул орчны агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл бага бөгөөд замын нөхцөл сайжирснаар шороон замаас үүсэх тоосны хэмжээ буурна.



Зураг 7. Замын барилгын ажлын үед үүсэх тоосны 24 цагийн дундаж агууламж

Шугам хоолойн газар шорооны ажил. Шугам хоолойн ажил нь нарийн зурвас газарт явагдах бөгөөд техник тоног төхөөрөмж хангалттай үед богино хугацаанд хийх боломжтой. Хөрсний төрөл, ухлагын гүнээс хамааруулж шуудууны ханын налууг дараах байдлаар тодорхойлно.

Цэвэр, бохир ус, дулан хангамжийн шугам хоолойн шуудууны гүнийг 2.1-3.2 метр, ёроолын өргөнийг 0.8 м, өнгөн хэсгийн өргөнийг 1.4 м гэж үзвэл трассын дагууд ойролцоогоор 30'734м³ хөрс чулуулгийг ухаж гаргах ба энэхүү үйл ажиллагаанаас үүсэх агаар бохирдуулах

бодисуудын тоо хэмжээг тооцсон.



Зураг 8. Дулааны шугамын барилгын үед үүсэх тоосны 24 цагийн дундаж агууламж



Зураг 9. Цэвэр усны шугамын барилгын ажлын үед үүсэх тоосны 24 цагийн дундаж агууламж

Шугам хоолойг суурилуулсны дараа ковш болон грейдер ашиглан булна гээд үүсэж болох тоос тоосонцрын хэмжээг дараах томъёонуудыг ашиглан тооцсон.

$$EF = k * (s/12)^a * (W * 1.1023/3)^b$$

Энд: EF- тоосны ялгарлын фактор - кг/км.явалт,

W-механизмын хүндийн жин-тн,

s- материалын шаварлагийн агууламж - %,

k-тоосонцрын аэродинамик диаметрийн коэффициент (PM тоосонцорт 0.42, нийт тоосонд 1.38), a-тоосонцрын аэродинамик диаметрийн коэффициент (PM тоосонцорт 0.9, нийт тоосонд 0.7), b=0.45.

Дулаан, цэвэр ус, ариутгах татуургын сүлжээний шугам хоолойн ажил нь нарийн зурвас

газарт, хэсэгчилсэн байдлаар явагдах бөгөөд PM_{10} тоосонцрын хоногийн дундаж агууламжийг хамгийн ихдээ $11.1-18.5 \text{ мкг/м}^3$ хүртэлх хэмжээгээр нэмэгдүүлэх ба энэ нь агаарын чанарын стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс нэлээд бага байгаа тул эдгээр үйл ажиллагаанаас орчны агаар чанарт үзүүлэх нөлөөлөл бага гэж үзэж болохоор байна .



Зураг 10. Бохир усны шугамын барилгын ажлын үед үүсэх тоосны 24 цагийн дундаж агууламж



Зураг 11. Хуваарилах болон нийгмийн барилга байгууламжийн барилгын үед үүсэх тоосны 24 цагийн дундаж агууламж

Хуваарилах байгууламжуудын болон нийгмийн барилга байгууламжийн барилгын ажлаас үүсэх тоос тоосонцор: Барилгын ажлын үед үүсэх тоос тоосонцрын хэмжээг Европын холбооны хүрээлэн буй орчны агентлагаас гаргасан аргачлалын дагуу тооцсон. Хуваарилах байгууламжууд болон нийгмийн барилга байгууламжууд нь хоорондоо зайтай бөгөөд барилгын ажил нь янз бүрийн хугацаанд хийгдэх ба тоос тоосонцрын тархалт нь үйл ажиллагаа явж буй талбайгаас 300 м хүртэлх зайд орчны агаар дах PM_{10} тоосонцрын хоногийн дундаж агууламжийг $5-50 \text{ мкг/м}^3$ хэмжээгээр нэмэгдүүлэхээр байна. Барилгын ажил нь богино хугацаанд хийгдэх тул орчны агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл бага байна.

Хийн хаягдал: Барилгын материал тээвэрлэх ба зам барилгын ажилд ашиглагдах хүнд даацын авто машин болон бусад тоног төхөөрөмж, машин механизмаас агаар бохирдуулагч бодисууд ялгарч, орчны агаарын чанарт сөргөөр нөлөөлнө. Мөн зам барилгын ажлын үед хайрган суурь, асфальт хучилт дэвсэх үед орчны агаарч хорт, хий, тортог, нарийн ширхэгт тоосонцор зэрэг бохирдуулагч бодис ялгарна. Агаарын бохирдол, ялангуяа химийн бохирдол нь автомашины түлшний шаталтын бүтээгдэхүүнээс шууд шалтгаалж байдаг. Автомашинаас хүрээлэн буй орчин, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн хэмжээ, цар хүрээ нь түүний утааны найрлагаас шууд хамаарч байдаг.

Автомашины утаанаас Cu, Ni, Cd, Hg зэрэг шатахууны найрлагын үндсэн хам бүрдлүүд, тэдгээрээс гадна Pb, Zn, Mn зэрэг нэмэлт хольцын элемент, тэднийг агуулагч нэгдлүүд нь хүрээлэн байгаа орчны агаарыг бохирдуулах нөхцөлтэй юм. Автомашины утааны найрлагад нийтдээ 200 гаруй төрлийн хорт бодис, химийн нэгдэл оролцдог. Зарцуулагдах түлшний жингийн 15% нь ашигтай зарцуулагдаж, үлдсэн 85% нь агаарт цацагддаг байна. 1 кг түлш шатаахдаа бензиний хөдөлгүүр 300-310 г, дизель хөдөлгүүр 80-100г хорт бодис ялгаруулдаг ажээ. 1кг шатахууныг литрт шилжүүлэн (бензин $q=0.725$, дизель $q=0.825$) бодож, түүний шаталтаас ялгаран гарах хорт хийн агуулалт, хэмжээг тооцоолон гаргасан. Автомашины утааны агаарыг бохирдуулах чанарыг тодорхойлохдоо, дизель хөдөлгүүрт бол хөө торгтийн агуулалтыг үндсэн үзүүлэлт болгодог.

Болзошгүй сөрөг нөлөөлөл

- Хаягдал шороон материал тээвэрлэх, ачиж буулгах зэрэг ажлуудыг зохих хамгаалалттайгаар хийж гүйцэтгээгүй нөхцөлд орчны агаарт тоосжилт үүсгэж болзошгүй.
- Замын ажилд ашиглах элс, хайрга, барилгын ажилд ашиглагдах цемент зэрэг нунтаг бодисууд, мод төмрийн үртэс, хаягдал материалууд салхинд дэгдэж орчны агаарт бохирдол үүсгэж болзошгүй.

Төслийг хэрэгжүүлэх явцад буюу барилгын ажлын явцад бий болох дээр дурдсан нөлөөллүүд нь зайлшгүй боловч түр зуурын шинж чанартай, дунд зэргийн эрчимтэй байх бөгөөд багавтар хэмжээний талбайг хамрах тул нөлөөллийн тархалт нь дунд зэрэг байна.

Ашиглалтын үед шинээр баригдах нийгмийн барилга байгууламжуудын орчимд замын хөдөлгөөний эрчим нэмэгдэх бөгөөд үүнээс улбаалан дизель болон бензин хөдөлгүүрээс гарах утаа буюу NO₂, SO₂ гэх мэт бохирдуулагчийн хэмжээ нэмэгдэнэ. Төслөөс агаарын чанарт үзүүлэх нөлөөллийн үнэлгээг Хүснэгт 12-д нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт 12. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээ

№	Сөрөг нөлөөлөл	Хэлбэр		Нөлөөллийн зэрэг				Нөлөөллийн үргэлжлэх хугацаа							
		Шууд	Дам	Маш бага	Бага	Дунд	Их	Аюултай	Түр зуурын	Богино хугацааны	Дунд хугацааны	Урт хугацааны	Байнгын		
Гол сөрөг нөлөөлөл															
1	Газар шорооны ажлын үед орчны агаарт 4,485.6 кг/жил тоосжилт үүснэ.											+			
2	Авто машин бусад тоног төхөөрөмж, машин механизмаас											+			

	хийн хаягдал ялгарна.											
3	Зам барилгын ажлын үед хайрган суурь, асфальт хучилт дэвсэх үед орчны агаарч хорт, хий, тортог, нарийн ширхэгт тоосонцор зэрэг бохирдуулагч бодис ялгарна.								+			
Болзошгүй сөрөг нөлөөлөл												
4	Хаягдал шороон материал тээвэрлэх, ачиж буулгах зэрэг ажлуудыг зохих хамгаалалттайгаар хийж гүйцэтгээгүй нөхцөлд орчны агаарт тоосжилт үүсгэж болзошгүй.								+			
5	Замын ажилд ашиглах элс, хайрга, барилгын ажилд ашиглагдах цемент зэрэг нунтаг бодисууд, мод төмрийн үртэс, хаягдал материалууд салхинд дэгдэж орчны агаарт бохирдол үүсгэж болзошгүй.									+		
Нөлөөллийн тоо		-	-	-	1	4	-	-	2	3	-	-
Нөлөөллийн хувь %		-	-	-	20	80	-	-	40	60	-	-
Дүгнэлт: Төслийн нийт хугацаанд агаарын чанарт үзүүлэх нөлөөллүүдийг тодорхойлж, тус бүрт нь үнэлгээ өглөө. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийн 25% нь баг, 75% нь дунд гэсэн ангилалд хамаарч байна. Төслийн үйл ажиллагаанаас үзүүлж байгаа нөлөөллүүд нь үргэлжлэх хугацааны хувьд 25% түр зуурын, 75% нь богино хугацааны нөлөөлөл байна. Төслийг хэрэгжүүлэх явцад нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд, болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж чадвал төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах боломжтой.												

3.3. Физик орчинд үзүүлэх нөлөөлөл

Гол сөрөг нөлөөлөл

Дуу чимээ: Барилгын ажлын үед явагдах газар шорооны ажлууд, барилга угсралтын ажил, инженерийн шугам хоолойн ажлууд, барилгын материал тээвэрлэх, ачиж, буулгах зэрэг ажлуудаас, зам барилгын ажлын үед явагдах талбайн цэвэрлэгээ, тэгшилгээ, хайрган үе дэвсэх, асфальт хучилт хийх зэрэг ажлуудаас дуу чимээ үүснэ. Барилгын ажлын үед ажиллах машин механизмын тоог нэгтгэн авч үзвэл 9-13 экскаватор, 26-40 самосвал, 8-11 ковш, 4-6 кран, 1-2 грейдер, 4-5 индүү, 1-2 усны машин, 4-6 материал тээвэрлэх шаланз гэх мэт нийт 30-50 тооны машин механизм ажиллана. Барилгын салбарт өргөнөөр ашиглагддаг хүнд даацын машин механизмуудаас үүсэх дуу чимээний тархалтын эрчмийг Хүснэгт 13-д үзүүлэв.

Хүснэгт 13. Машины механизмаас үүсэх дуу чимээний тархалтын эрчим

Машин механизм	Зай									
	5м	10м	20м	40м	60м	80м	100м	150м	200м	300м
Дугуйт ачигч	90	84	78	72	68.5	66	64	60.5	58	54.5
Бульдозер	86	80	74	68	64.5	62	60	56.5	54	50.5
Грейдер	90	84	78	72	68.5	66	64	60.5	58	54.5
Экскаватор	84	78	72	66	62.5	60	58	54.5	52	48.8
Индүүдэгч	87	81	75	69	65.5	63	61	57.5	55	51.5
Ачааны машин	87	81	75	69	65.5	63	61	57.5	55	51.5

Барилгын үйл ажиллагаанаас үүсэх дуу чимээний нөлөөлөл нь богино хугацаанд үргэлжлэх, дун зэргийн тархалт, дунд зэргийн эрчимтэй нөлөөлөл байна.

Төслийн үйл ажиллагаанаас хог хаягдал үүсэх

- Барилгын түр кемпүүдээс барилгын ажил явагдах нийт хугацааны туршид 164.88 тонн хатуу, 845.1 м³ шингэн хаягдал тус тус үүснэ.
- Барилгын ажлуудаас нийт 69,171.96 м³ хаягдал шороон материал, барилгын материалын сав баглаа боодол, мод, тоосго, элс, хайрга, төмрийн үртэс зэрэг барилгын хог хаягдал үүснэ.

Ахуйн хог хаягдал: Толгойт дэд төвд явагдах барилгын үйл ажиллагааны төрлөөс шалтгаалан тодорхой хэмжээний ахуйн хатуу хог хаягдал байнга гарна. Эдгээр хог хаягдлын хэлбэр, хэмжээ болон эд материалын төрөл зүйл янз бүр байх боловч ихэнх нь хуванцар болон шилэн сав, лааз, хүнсний ногоо, баглаа боодол, цаас, даавуу, ариун цэврийн хэрэглэл, нийлэг болон бусад эдүүд байна.

Барилгын ажил явагдах 2 жилийн хугацаанд барилгын багц тус бүрт үүсэх хог хаягдлын хэмжээг “Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30.01.03.-ийн Зөвлөмжийн 16-р хавсралт: Ахуйн хаягдал цуглуулах нормативын жилийн хугацаанд 1 хүнд ноогдох хаягдлын хэмжээ”-г үндэслэн тооцож Гүйцэтгэгчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд (Г-БОМТ) оруулж өгөх шаардлагатай. Нэг хүнээс хоногт дунджаар 0.8 кг байхаар бодож барилгын ажлын үед үүсэх ахуйн хатуу хог хаягдлыг дараах томъёогоор тооцно.

$$X_{ж} = (X_{х} \cdot N_{х} \cdot A_{ж}) / 1000 \text{ тн/нийт}$$

Энд: $X_{ж}$ ахуйн хатуу хог хаягдал, тн/нийт

$X_{х}$ - ажиллагчдын тоо

$N_{х}$ - хоногт нэг хүнээс гарах хатуу хаягдлын норм, кг

$A_{ж}$ -барилгын ажил гүйцэтгэх хугацаа /12 сар/

Шингэн хаягдлын хэмжээг тооцоолох норматив аргачлал: Нэг хүнээс хоногт дунджаар 4.1 литр шингэн хаягдал гарна гэсэн норматив өгөгдлийг тухайн барилгын ажлын багцад ажиллах хүний тоо, барилгын ажил явагдах өдрийн тоогоор үржүүлж шингэн хаягдлын хэмжээг тооцоолно.

Болзошгүй сөрөг нөлөөлөл

- Барилгын ажил явагдах цэгүүдийн ойр орчимд замбараагүй хаясан шил, хуванцар сав, тамхины иш зэрэг нь физик орчинд бохирдол үүсгэж болзошгүй.
- Барилгын ажил дууссаны дараа хог хаягдлыг цуглуулж зайлуулах, талбайн цэвэрлэгээ зэрэг ажлыг гүйцэд хийгээгүйн улмаас хаягдал барилгын материал, элс, хайрга, цемент зэрэг материалууд үлдэж орчны бохирдол үүсгэж болзошгүй.

Эерэг нөлөөлөл

- Төслийн барилгын үйл ажиллагаа эхлэхэд 350 айлыг нүүлгэн шилжүүлнэ.
- Агаар бохирдуулагч эх үүсвэрийн сайжруулсан нүүрсэн түлш түлдэг зуухны тоо 6860-ээр цөөрнө. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй сургууль цэцэрлэгүүдийн дэд бүтцийг бие даасан дэвшилтэт технологиор шийдвэрлэх буюу 9 сургуулийн халаалтын зуухыг хийн халаалтын зуухаар солино.
- Гэр хорооллын нэг өрх жилд 5 тонн нүүрс түлдэг гэж үзвэл нүүрсний хэрэглээг жилд 34,2507 тонноор багасгаснаар нүүрсхүчлийн хий, тоос тортог, хүхрийн давхар исэл, азотын давхар исэл зэрэг агаар бохирдуулагч бодисын ялгарал буурна.
- Толгойт дэд төвд нүүрсний хэрэглээг төвийн дулаан хангамжаар сольсноор үнсэн хаягдлын хэмжээг жилд 7,192.58 тонноор багасгана.

Төслөөс физик орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг Хүснэгт 14-д нэгтгэн үзүүлэв.


Хүснэгт 14. Физик орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээ.

№	Сөрөг нөлөөлөл	Хэлбэр		Нөлөөллийн зэрэг					Нөлөөллийн үргэлжлэх хугацаа				
		Шууд	Дам	Маш бага	Бага	Дунд	Их	Аюултай	Түр зуурын	Богино хугацааны	Дунд хугацааны	Урт хугацааны	Байнгын
Гол сөрөг нөлөөлөл													
1	Газар шорооны ажил, барилга угсралт, шугам хоолойн угсралт, барилгын материал тээвэрлэх, ачих, буулгах ажлуудаас дуу чимээ үүснэ..									+			
2	Хаягдал шороон материал, барилгын материалын сав баглаа боодол, мод, тоосго, төмрийн үртэс зэрэг барилгын хог хаягдал үүснэ.									+			
3	Барилгын түр кемпүүдээс 164.88 тонн хатуу ба 845м ³ ахуйн шингэн хаягдал үүснэ.									+			
Болзошгүй сөрөг нөлөөлөл													
4	Барилгын ажил явагдах цэгүүдийн ойр орчимд замбараагүй хаясан шил, хуванцар сав, тамхины иш зэрэг нь физик орчинд бохирдол үүсгэж болзошгүй.									+			
5	Барилгын ажил дууссаны дараа хог хаягдлыг цуглуулж зайлуулах, талбайн цэвэрлэгээ зэрэг ажлыг гүйцэд хийгээгүйн улмаас хаягдал барилгын материал, элс, хайрга, цемент зэрэг материалууд үлдэж орчны бохирдол үүсгэж болзошгүй.									+			
Нөлөөллийн тоо		-	-	-	2	3	-	-	-	5	-	-	-
Нөлөөллийн хувь %		-	-	-	40	60	-	-	-	100	-	-	-
Дүгнэлт:													
Төслийн барилгын ажлын хугацаанд физик орчинд үзүүлэх нөлөөллүүдийг тодорхойлж, тус бүрт нь үнэлгээ өглөө. Төслийн үйл ажиллагаанаас физик орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн 40% нь бага, 60% нь дунд зэрэг гэсэн ангилалд хамаарч байна. Төслийн үйл ажиллагаанаас үзүүлж байгаа нөлөөллүүд нь үргэлжлэх хугацааны хувьд 100% богино хугацааны нөлөөлөл байна. Төслийг хэрэгжүүлэх явцад нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж чадвал төслийн үйл ажиллагаанаас физик орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах боломжтой.													

3.4. Гадаргын усанд үзүүлэх гол болзошгүй сөрөг нөлөөлөл

Улаанбаатар хотын дэвсгэр талбай болон зэргэлдээх зарим дүүргийн бүс нутаг нь газар зүйн байршлын хувьд ойт хээрийн бүсэд 1950-2265 м үнэмлэхүй өндөртэй Богдхан, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх зэрэг өндөр уулсын муж, түүнчлэн Туул голын ай сав, түүний хажуу жигүүрийн жижиг цутгал голуудын хөндийн хэмжээнд багтаж байрладаг. Улаанбаатар хотын ихэнх барилга байгууламж нь Туул голын хөндийн ай сав болон Сэлбэ голын адаг хэсэгт тархан байрласнаас гадна Зүүн, Баруун Наран, Цагаан хуарангийн дэнжид гол барилга, байгууламж тархжээ.

Төслийн талбай нь ус зүйн хувьд дэлхийн ус хагалбарын Хойд мөсөн далайн ай савд, Монгол орны Туул голын сав газарт багтана.



Зураг 12. Төслийн талбай орчмын гадаргын усан сүлжээ

Сонгинохайрхан дүүргийн 1,2,3,20,35 -р хорооны хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Толгойт дэд төв барих” төслийн талбай орших бүс нутаг нь ус зүйн хувьд дэлхийн ус хагалбарын Хойд мөсөн далайн ай савд, Монгол орны Туул голын сав газарт багтана. Энэ бүс нутагт байгалийн тогтоц, уур амьсгалын нөхцөлөөс хамааран гадаргын усан сүлжээ харьцангуй сайн хөгжсөн. Төслийн талбайд ойролцоо орших гадаргын усан сүлжээ нь Улиастай, Туул голууд бөгөөд төслийн талбайд хамгийн ойрхон нь 500м зайтай Сэлбэ гол болон Тахилтын гол юм.

Хүснэгт 15. Гадаргын усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл.

№	Сөрөг нөлөөлөл	Хэлбэр		Нөлөөллийн зэрэг				Нөлөөллийн үргэлжлэх хугацаа					
		Шууд	Дам	Маш бага	Бага	Дунд	Их	Аюултай	Тур зуурын	Богино хугацааны	Дунд хугацааны	Урт хугацааны	Байнгын
Гол сөрөг нөлөөлөл													
1	Ажилчдын кемпээс үүсэх ахуйн хатуу, шингэн хог хаягдал зэрэг нь хур борооны усаар зөөгдөн урсаж гадаргын усны бохирдол үүсгэх									+			
2	Инженерийн шугам сүлжээ татах суваг шуудууг ухах, авто зам барих, зам доогуурх ус нэвтрүүлэх хоолой тавих зэрэг ажлаас гэр хороолол доторх үерийн урсцын жалга, сувгуудын бүтэц, хэлбэр,									+			

	чиглэл түр хугацаанд буюу бүрмөсөн өөрчлөгдөх											
Болзошгүй сөрөг нөлөөлөл												
3	Их хэмжээний хур бороо орсны улмаас барилгын ажил явагдаж буй зам, талбай үерт автаж, машин техник эвдэрч гэмтэх, хүн осолдох, барилгын материал урсах зэрэг эрсдэлүүд тохиолдох											
4	Тос тосолгооны материал, замын ажилд ашиглагдах асфальт бетон зуурмаг зэрэг бодис санамсаргүй байдлаар асарч хөрсөнд алдагдан, улмаар хур борооны усаар зөөгдөн гадаргын усан сүлжээний усны найрлага, чанарт дам байдлаар нөлөөлж болзошгүй.											
Нөлөөллийн тоо		-	-	-	2	2	-	-	1	3	-	-
Нөлөөллийн хувь %		-	-	-	50	50	-	-	25	75	-	-
Дүгнэлт: Төслийн барилгын ажлын хугацаанд физик орчинд үзүүлэх нөлөөллүүдийг тодорхойлж, Төслийн нийт хугацаанд гадаргын усанд үзүүлэх нөлөөллүүдийг тодорхойлж, тус бүрт нь үнэлгээ өглөө. Төслийн үйл ажиллагаанаас гадаргын усанд үзүүлэх сөрөг нөлөөллийн 50% нь бага, 50% нь дунд гэсэн ангилалд хамаарч байгаа ба үргэлжлэх хугацааны хувьд 25% нь түр зуурын, 75% богино хугацааны нөлөөлөл байна. Төслийн хэрэгжилтийн явцад нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд, тэдгээрийн үр дүнг хянах хяналт шинжилгээний хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж чадвал төслийн үйл ажиллагаанаас гадаргын усанд үзүүлэх нөлөөллийг бүрэн бууруулах боломжтой..												


3.5. Газрын доорх усанд үзүүлэх гол болзошгүй сөрөг нөлөөлөл

Төсөл хэрэгжих талбайн инженер-геологийн нөхцөл: Судалгаанд хамрагдсан дэвсгэр талбайн хэмжээнд тухайн бүс нутгийн шинж төрхтэй гидрогеологийн нөхцөлийг илэрхийлж буй газрын доорх усны тархалт, бүрэлдэн тогтолтын байгалийн ерөнхий зүй тогтолт болон геологийн тогтцын суурь нөхцөлийн өвөрмөц онцлогийг үндэслэн, гидрогеологийн давхарга зүйчлэлийн хувьд дараах уст үе давхарга, цогцолбор, газрын доорх усны бусад хуримтлал, бөөгнөрлийг ялгаж байна Үүнд:


- Голоцены үеийн аллювийн гарал үүсэлтэй сэвсгэр хурдасны уст давхарга (aIQ2)
- Дунд-дээд плейстоцений үеийн делюви-пролювийн гарал үүсэлтэй сэвсгэр хурдасны уст давхарга (dpQ1-2)
- Доод-дунд карбоны настай тунамал-хувирмал чулуулгийн зузаалаг дахь уст цогцолбор (C 1-2) зэрэг болно.

Цэвдгийн тархац: Монгол орны цэвдэг тархах боломжит талбайн 23.2 % нь Хэнтийн уулархаг бүс нутагт ноогдох бөгөөд үргэлжилсэн тархалттай цэвдэг 4503 км², тасалданги тархалттай цэвдэг 33631 км², алаг цоог тархалттай цэвдэг 25839 км², тохиолдлын тархалттай цэвдэг 43534 км² талбайг тус тус эзэлнэ. Энэ бүс нутгийн цэвдгийн тархалтад хурдас чулуулаг, ургамлын хэв шинжийн ялгаатай байдал нь гол хүчин зүйл болдог бөгөөд цэвдгийн тархалтын доод хил Хэнтийн баруун хойд хэсэгт 800-900 м, баруун хэсэгт 900-1300 м, өвөр хэсэгт 1400-1600 м, зүүн, зүүн хойд хэсэгт 1000-1200 метрийн өндөрт тус тус байна. Толгойт дэд төв нь Монгол орны цэвдгийн тархалтын мужлалаар алаг цоог тархалттай цэвдгийн бүсэд хамаарагдана. Цэвдгийн дээд хил (улирлын гэсэлтийн гүн)-ийн жилийн дундаж температур нь алаг цоог тархалттай бүслүүрт -1°C – 0°C, харин улирлын хөлдөлтийн гүний жилийн дундаж температур улирлын хөлдөлтийн бүсэд > 1°C байдаг бөгөөд хөрсний улирлын хөлдөлтийн норматив гүн нь 5.1 метр байна. 2016-2035 оны хугацаанд нийт Монгол орны цэвдгийн тархалтын хувь нь 29.3%-аас 5.9% нь алдралд орж 23.4% болж буурах дүр зураг ажиглагдаж байна (Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий

төслийн Цэвдэг, хүйтний үзэгдлийн тархалтын үнэлгээ сэдэвт судалгааны ажлын үр дүнг хураангуйлан оруулав. Зохиогч ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн Цэвдэг судлалын салбарын дарга, доктор А.Дашцэрэн, 2020).



Зураг 13. Төслийн талбай орчмын гидрогеологи



Зураг 14. Монгол орын цэвдгийн тархалт

Гидро-техникийн нөхцөл: Толгойт голын хөндийн ай савын хэмжээнд гарал үүсэлтэй дөрөвдөгчийн элс, хайргархаг сэвсгэр хурдсанд газрын доорх усны байгалийн тодорхой нөөц баялаг хуримтлагдан бий болсон байна. Гэвч дээр дурдсан дэвсгэр талбайд болон түүний хоёр талын хажуу жигүүрийн хэсгээр гэр хороолол, хувийн орон сууцны бэсрэг

цогцолбор, зуслангийн байр зэрэг объектууд маш ихээр бөөгнөрч төвлөрөн нэлээд шигүү суурьшсан тул уг хэсэгт гаргасан худгийн усыг авч унд-ахуйд хэрэглэсэн тохиолдолд тухайн орчинд тархсан газрын доорх чөлөөт гадаргуутай ус нь газрын гадаргуугаас зонхилон өдөөгдсөн төрөл бүрийн бохирдолд шууд өртөж, чанар найрлага, бодисын зүйн шинж төлөв нь эрс муудаж, хүн амын дунд халдварт өвчин эмгэг үүсэж болзошгүй нөхцөл байдал бүрэлдэн бий болжээ.

3.6. ГАЗРЫН ДООРХ УСНЫ ЧАНАР

Төслийн талбайд 2022 оны 4 дугаар сард хийсэн хээрийн ажлын үер Сонгинохайрхан дүүргийн 2-р хорооны нутаг дэвсгэрт орших 207-р худгаас дээжлэлт хийсэн. Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн , чанарын хувьд нэн цэнгэг буюу ялимгүй эрдэсжилттэй, маш зөөлөн ус байна.

Гол сөрөг нөлөөлөл

Төслийг хэрэгжүүлэх явцад газрын доорх усны нөөцийг бага хэмжээгээр, зөвхөн тухайн цэг дээрх цөөн тооны барилгын ажилчдын ахуйн хэрэгцээ болон хуурай өдрүүдэд тоосжилт дарах зорилгоор ашиглахаар төлөвлөсөн байна. Газрын доорх усны нөөц ашиглах хэмжээ нь нэгэнтээ бага хэмжээтэй, мөн түүнчлэн барилгын ажил нь 1-2 жилийн хугацаанд үргэлжлэх богино хугацааны шинж чанартай тул газрын доорх усны нөөц ашиглах шинэ эх үүсвэр бий болгох шаардлагагүй гэж үзсэн. Барилгын ажилчдын ундны усны хэрэгцээг үйлдвэрийн савлагаат ус худалдан авч хангах ба барилгын ажилд хэрэглэгдэх усыг ойролцоох автомат тоолууртай худгаас худалдан авч ашиглана. Барилгын ажлын явцад шинээр худаг гарган ашиглахгүй ба ашиглагдах усны хэмжээ багавтар байх тул төслөөс газрын доорх усанд үзүүлэх шууд сөрөг нөлөөлөл байхгүй.

Болзошгүй сөрөг нөлөөлөл

- Барилгын ажлын явцад шатах, тослох материал, замын ажилд ашиглагдах асфальт бетон зуурмаг зэрэг бодис асгарч хөрсөнд шингэн, улмаар бага гүний уст үеүдийг бохирдуулж болзошгүй
- Барилгын түр кемпүүдийн үйл ажиллагаанаас үүсэх шингэн хаягдал, 00-д хуримтлагдсан ялгадас зэрэг нь хөрсөнд нэвчиж газрын доорх усны найрлага, чанарт нөлөөлж болзошгүй.

Хүснэгт 16. Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээ.

№	Сөрөг нөлөөлөл	Хэлбэр		Нөлөөллийн зэрэг				Нөлөөллийн үргэлжлэх хугацаа					
		Шууд	Дам	Маш бага	Бага	Дунд	Их	Аюултай	Түр зуурын	Богино хугацааны	Дунд хугацааны	Урт хугацааны	Байнгын
Болзошгүй сөрөг нөлөөлөл													
1	Барилгын ажил явагдах Барилгын ажлын явцад шатах, тослох материал, асфальт бетон зуураг зэрэг бодис асгарч хөрсөнд шингэн, улмаар бага гүний уст үеүдийг бохирдуулж болзошгүй									+			
2	Барилгын түр кемпүүдийн үйл									+			

ажиллагаанаас үүсэх шингэн хаягдал, 00-д хуримтлагдсан ялгадас зэрэг нь хөрсөнд нэвчиж газрын доорх усны найрлага, чанарт нөлөөлж болзошгүй.													
Нөлөөллийн тоо	-	-	-	2	-	-	-	-	-	2	-	-	-
Нөлөөллийн хувь %	-	-	-	100	-	-	-	-	-	100	-	-	-
Дүгнэлт: Төслийн барилгын ажлын хугацаанд физик орчинд үзүүлэх нөлөөллүүдийг тодорхойлж, Төслийн нийт хугацаанд газрын доорх усанд үзүүлэх нөлөөллүүдийг тодорхойлж, тус бүрт нь үнэлгээ өглөө. Төслийн нийт үйл ажиллагаанаас газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь 100% нь бага зэргийн эрчимтэй байх ба үргэлжлэх хугацааны хувьд 100% богино хугацааны нөлөөлөл байна. Төслийн хэрэгжилтийн явцад нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд, тэдгээрийн үр дүнг хянах хяналт шинжилгээний хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж чадвал төслийн үйл ажиллагаанаас газрын доорх усанд үзүүлэх нөлөөллийг бууруулах бүрэн боломжтой.													

Дүгнэлт. Төсөл хэрэгжүүлэгчийн төлөвлөсөн барилгын ажилчдын унд ахуйн хэрэгцээг дэлгүүрийн савлагаат ус худалдан авах байдлаар, ахуйн хэрэгцээг ойролцоох ус түгээх төвөөс зориулалтын саванд ус худалдан авах байдлаар хангахаар сонгосон арга нь байгаль орчин ба хүний эрүүл мэндэд халгүй байдлаар ажиллах бүрэн боломжтой гэж дүгнэж байна. Төслийн үйл ажиллагаанаас газрын доорх усанд үзүүлэх шууд нөлөөлөл байхгүй ба болзошгүй нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлсэн нөхцөлд зайлсхийх бүрэн боломжтой юм Төсөл хэрэгжих явцад үүсэж болзошгүй дээрх нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлсэн нөхцөлд зайлсхийх бүрэн боломжтой бөгөөд түр зуурын шинж чанартай нөлөөллүүд байна. Төслийн үйл ажиллагаанаас газрын доорх усанд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг Хүснэгт 16-д нэгтгэн үзүүлэв.

3.7. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл

Тус төслийн хүрээнд Авто зам 4 эгнээ бүхий зам 1.97 км, 2 эгнээ бүхий зам 4.067км, дугуйн зам 5.9 км, Дулаан хангамжийн 6.728 км, Ариутгах татуургын 12.094 км шугам, цэвэр усны 7.38 км шугам, цахилгааны кабелийн 90.0 км шугам, холбооны 7.1 км шугам сүлжээ татах, Сургалтын төв, 5.375 км үерийн суваг тохижуулах зэрэг ажлаас нийт 12.4 га талбайн эвдрэлд өртөж, хөрсөн бүрхэвчинд, богино хугацааны эвдрэл үүснэ. Төсөл хэрэгжих талбай нь өнөөгийн байдлаар автомашин ба хүний хөдөлгөөний нөлөөгөөр хөрсний эвдрэл ихтэй, хөрсөн бүрхэвчийн элэгдэл явагдаж суларсан зэрэг нийтлэг байдал ажиглагдаж байна. Толгойт төвд 1.97 км авто зам барих ажилд шороон ба хайрган материалын карьер шинээр нээж ашиглахгүй бөгөөд замын ажилд шаардагдах элс, хайрга, бетон зуурмаг, асфальт материалын Улаанбаатар хот дахь тухайн чиглэлийн үйлдвэрийн газруудаас худалдан авахаар төлөвлөсөн. Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид дараах нөлөөллийг үзүүлнэ.

Гол сөрөг нөлөөлөл

- 12.4 га талбайн газар шорооны ажлын үед нийт 109159,81м³ хөрс хуулалт хийж, хөрсөн бүрхэвчийн эвдрэл үүснэ.
- Барилгын ажил явагдаж буй цэгүүдийн орчимд, ажилчдын кемп орчимд машин тэрэг, хүний байнгын хөл хөдөлгөөнөөс үүдэн хөрс суларч доройтон, хөрсний элэгдэл үүснэ.

Болзошгүй сөрөг нөлөөлөл

- Шимт хөрсний овоолгыг стандартын дагуу үүсгэж хадгалаагүй нөхцөлд хөрсний чанар алдагдаж болзошгүй.
- Барилгын ажлын явцад шатах, тослох материал, замын ажилд ашиглагдах асфальт бетон зуурмаг зэрэг бодис асарч гоожин хөрсөнд нэвчсэнээр хөрсөн бүрхэвчийн

бохирдол үүсгэж болзошгүй.

- Барилгын болон ахуйн хог хаягдлыг замбараагүй зайлуулах болон ажилчдын кемпээс гарах бохир ус, бие засах газар, ахуйн бохирдлоос үүдэлтэй хөрсний бохирдол үүсэж болзошгүй.

Хүснэгт 17. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээ.

№	Сөрөг нөлөөлөл	Хэлбэр		Нөлөөллийн зэрэг				Нөлөөллийн үргэлжлэх хугацаа					
		Шууд	Дам	Маш бага	Бага	Дунд	Их	Аюултай	Тур зуурын	Богино хугацааны	Дунд хугацааны	Урт хугацааны	Байнгын
Гол сөрөг нөлөөлөл													
1	1.7 талбайд хийгдэх газар шорооны ажлын улмаас нийт 1,615м ³ хөрс хуулалт хийгдэж, хөрсөн бүрхэвчийн эвдрэл үүснэ.									+			
2	Барилгын ажил явагдаж буй цэгүүдийн орчимд, ажилчдын кемпийн орчимд машин тэрэг, хүний байнгын хөл хөдөлгөөнөөс үүдэн хөрс суларч доройтох, хөрсний элэгдэл үүснэ.									+			
Болзошгүй сөрөг нөлөөлөл													
3	Шимт хөрсний овоолгыг стандартын дагуу үүсгэж хадгалаагүй нөхцөлд хөрсний чанар алдагдаж болзошгүй.									+			
4	Тос тосолгооны материал санамсаргүй байдлаар асгарч гоожин хөрсөнд нэвчсэнээр хөрсөн бүрхэвчийн бохирдол үүсгэж болзошгүй.									+			
5	Барилгын болон ахуйн хог хаягдлыг замбараагүй зайлуулах болон ажилчдын кемпээс гарах бохир ус, бие засах газар, ахуйн бохирдлоос үүдэлтэй хөрсний бохирдол үүсэж болзошгүй.									+			
Нөлөөллийн тоо				-	1	4	-	-	-	5	-	-	-
Нөлөөллийн хувь %				-	20	80	-	-	-	100	-	-	-
Дүгнэлт													
Төслийн нийт хугацаанд хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллүүдийг тодорхойлж, тус бүрт нь үнэлгээ өглөө. Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийн 20% нь бага, 80% нь дунд зэрэг гэсэн ангилалд хамаарч байна. Төслийн үйл ажиллагаанаас үзүүлж байгаа нөлөөллүүд нь үргэлжлэх хугацааны хувьд 100% богино хугацааны нөлөөлөл байна. Төслийн хэрэгжилтийн явцад нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд, тэдгээрийн үр дүнг хянах хяналт шинжилгээний хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж чадвал төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийг бууруулах боломжтой.													

3.8. УРГАМЛЫН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн талбай нь суурьшлын бүсийн төв дунд, хүний хөл хөдөлгөөний эрчим өндөртэй

газарт байрлах тул ямар нэгэн ногоон байгууламж буюу ургамлын бүрхэвч байхгүй бөгөөд олон арван жилийн хүний хөл хөдөлгөөний улмаас ургамлын бүлгэмдэл маш хүчтэй нөлөөлөлд өртсөн байна. Толгойт дэд төвд хийж гүйцэтгэсэн ургамлын нөмрөгийн судалгаагаар төслийн талбайд ургамлын бүрхэц бүхий талбай маш бага бөгөөд бүрхцийн дийлэнх хувийг нь ширэг улалж, ямаан шарилж, ээрэм шарилж, цагаан лууль зэрэг хөл газрын ургамлууд бүрдүүлж байна.

Төслийн хүрээнд баригдах хүүхдийн цэцэрлэгийн гадна талбайн 10-аас доошгүй хувьд нь, Толгойт үерийн сувгийн тохижилтын ажлын хүрээнд үерийн суваг дагуу хөл газрын ургамлыг түүж цэвэрлэн, мод бут тарьж, зүлэгжүүлэлт хийх зэргээр ногоон байгууламж үүсгэх юм. Ногоон байгууламж огт байхгүй Толгойт дэд төвийн суурьшлын бүс дотор шинээр ногоон байгууламж үүсгэн бий болгох тул төсөл нь ургамлын бүрхэвчийн хувьд эерэг нөлөөлөл үзүүлнэ.

Төслийн үйл ажиллагаанаас ургамлын бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл байхгүй болно.

3.9. Ан амьтанд үзүүлэх нөлөөлөл

Төслийн талбай нь Толгойт гэр хорооллын суурьшлын бүсийн төв дунд, хүний хөл хөдөлгөөний эрчим өндөртэй газарт төв зам дагуу байрлах тул ан амьтан байхгүй юм. Иймд, төслийн үйл ажиллагаанаас ан амьтанд үзүүлэх нөлөөлөл байхгүй болно.

3.10. Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх нөлөөлөл

Толгойт дэд төв нь Богдхан уулын ДЦГ-аас 5.5 км, Чингэлтэй уулын тусгай хамгаалалттай газраас 17.6 км зайд тус тус орших тул төслийн үйл ажиллагаанаас ТХГН-т үзүүлэх нөлөөлөл байхгүй болно.

3.11. Түүх, соёлын өвд үзүүлэх нөлөөлөл

Төслийн ажил явагдах талбайд илэрсэн ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл байхгүй тул төслийн үйл ажиллагаанаас түүх, соёлын өвд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл байхгүй болно. Харин төслийн газар шорооны ажлын явцад газрын хөрсөн доор нуугдмал байдлаар оршин байсан археологи, палеонтологийн санамсаргүй олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрч болзошгүй.

Хүснэгт 18. Түүх соёлын өвд үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээ

№	Сөрөг нөлөөлөл	Хэлбэр		Нөлөөллийн зэрэг					Нөлөөллийн үргэлжлэх хугацаа				
		Шууд	Дам	Маш бага	Бага	Дунд	Их	Аюултай	Түр зуурын	Богино хугацааны	Дунд хугацааны	Урт хугацааны	Байнгын
Болзошгүй сөрөг нөлөөлөл													
1	Төслийн газар шорооны ажлын явцад газрын хөрсөн доор нуугдмал байдлаар оршин байсан археологи, палеонтологийн санамсаргүй олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрч болзошгүй.								+				
Нөлөөллийн тоо				1	-	-	-	-	1	-	-	-	-
Нөлөөллийн хувь %				100	-	-	-	-	100	-	-	-	-

Дүгнэлт

Төслийн нийт хугацаанд түүх соёлын өвд үзүүлэх нөлөөллүүдийг тодорхойлж, тус бүрт нь үнэлгээ өглөө. Төслийн үйл ажиллагаанаас түүх, соёлын өвд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь 100% маш бага гэсэн ангилалд хамаарах ба үргэлжлэх хугацааны хувьд 100% нь богино хугацааны нөлөөлөл байна. Төслийн хэрэгжилтийн явцад нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг үр дүнтэй хэрэгжүүлж чадвал төслийн үйл ажиллагаанаас түүх соёлын өвд үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх бүрэн боломжтой.

3.12. Нийгэм, олон нийтэд үзүүлэх нөлөөлөл

Толгойт бүсэд сургууль цэцэрлэгийн хүрэлцээ маш муу байна. Сонгинохайрхан дүүрэг бол Улаанбаатар хотын нэн ядуу буюу тусгаарлагдсан дүүргүүдийн нэг бөгөөд оршин суугчдын талаас илүү хувь нь хамгийн ойрын сургууль цэцэрлэгээс 40 минут алхах зайнд хол амьдардаг. Толгойт бүсийн бүх сургууль цэцэрлэгүүд анх зориулагдсан хүчин чадлаас 2 дахин илүү ачаалалтай ажиллаж байна. БСШУЯ-аас 2019 онд 1,2 болон 22-р хороодод нийт 650 хүүхдийн 4 цэцэрлэг барихаар төлөвлөсөн ч тэдгээрийн байршил нь дэд төвийн гадна байна. Мөн 2019 онд 1-р хорооны 106-р сургуульд 640 хүүхдийн, 107-р сургуульд 320 хүүхдийн багтаамжтай өргөтгөл хийхээр төлөвлөсөн байна. Энэхүү өргөтгөл нь одоо суралцаж буй хүүхдүүдэд чанартай боловсрол олгох орчин нөхцөлийг бүрдүүлэхэд тус дэм болох боловч цаашдын хүн амын өсөлтийг тооцож үзвэл хангалтгүй байхаар байна.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Энэхүү төлөвлөгөөний зорилго нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, ерөнхий үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг хянах, илрүүлэх, бууруулах, байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд үр дүнтэй байгаа эсэхийг тогтооход оршино.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-ны Сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-д заагдсан бүтэц, агуулга, аргачлалын дагуу боловсруулав. БОМТ нь Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, Орчны тохижилт нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө, Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр, БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь зэргээс бүрдэнэ.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих, тайлагнах эрх үүргийг төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон Улаанбаатар хотын захиргаа, түүнийг төлөөлөн төслийг өдөр тутмын удирдлагаар ханган ажиллаж буй ТУН хүлээх бол БОМТ-д заагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллах үүргийг барилгын ажлын гэрээт гүйцэтгэгч байгууллагууд хүлээнэ. БОМТ-г хэрэгжүүлэх төсөв зардлыг барилгын ажлын гэрээнд тусган оруулж өгөх бөгөөд гэрээт гүйцэтгэгч байгууллагууд нь барилгын ажлын явцад талбайн байгаль орчны ажилтан авч ажиллуулах үүргийг хүлээнэ.

БОМТ үндсэн зорилгоо хангахын тулд төсөл хэрэгжүүлэгчийн санхүүгийн чадавхын хүрээнд нийгмийн хариуцлагыг өндөржүүлэхэд чиглэсэн дараах бодлогыг баримтална. Үүнд:

1. БОМТ-нд тусгасан ажлын дараалал, түүнийг хийж гүйцэтгэснээр хүрэх үр дүнг төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа, санхүүгийн боломж нөөцтэй уялдуулах;
2. БОМТ-ний хэрэгжилтийг компанийн удирдлага өөрөө болон орон нутгийн оршин суугчдын зүгээс хэрхэн хянаж, харилцан хамаарал бүхий бодит үр дүнд хүрэх;
3. БОМТ-г зохих ёсоор хэрэгжүүлснээр лабораторийг хөндлөнгийн хяналт, шалгалтад бэлэн байлгах зэрэг нөхцөлүүдийг тодорхойлно.
4. БОМТ-д тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ажилчдын үүрэг хариуцлагын тогтоосон удирдлагын шатлал дараалал бий болно.
5. Ажилчид бүр байгаль орчныг хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон байхын зэрэгцээ тэдэнд биелүүлэхэд нь туслах бэлтгэл сургалт, ур чадвартай мэргэжилтэнтэй болсон байна.
6. Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилан тооцож, байгаль орчинд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, орчны чанарыг сайжруулах, хэвийн нөхцөлийг хадгалж, хамгаална.
7. Орон нутгийн удирдлага, хяналтын байгууллага, иргэдтэй байгаль орчныг хамгаалах асуудлаар зөвлөлдөж, тэдний санал, хүсэлтийг хүлээн авч, хамтран ажиллана.
8. Байгаль орчны асуудлаарх төрийн захиргаанаас өгсөн санал зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Энэхүү төлөвлөгөөний зорилго нь төсөл хэрэгжих Толгойт дэд төвийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, ерөнхий үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга

хэмжээнүүд үр дүнтэй байгаа эсэхийг тогтооход оршино. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө, Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө, Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө, Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр, БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь зэргээс бүрдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль Орчин Аялал Жуулчлалын Сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-д заагдсан бүтэц, агуулга, аргачлалын дагуу боловсруулав. Толгойт дэд төв нь нийт 554.4 га талбайг хамрах ба засаг захиргааны хил хязгаарын хувьд Сонгинохайрхан дүүргийн 1,2,3,20,34,35 дугаар хороодын нутаг дэвсгэрт хэрэгжих юм.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь 2025 онд хэрэгжих бөгөөд БОМТ-ний биелэлтэд хяналт тавих, тайлагнах эрх үүргийг төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон Улаанбаатар хотын захиргаа, түүнийг төлөөлөн төслийг өдөр тутмын удирдлагаар ханган ажиллаж буй Төслийн Удирдах Нэгж хүлээх бол БОМТ-д заагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллах үүргийг барилгын ажлын гэрээт гүйцэтгэгч байгууллагууд хүлээнэ. БОМТ-г хэрэгжүүлэх төсөв зардлыг барилгын ажлын гэрээнд тусган оруулж өгөх бөгөөд гэрээт гүйцэтгэгч байгууллагууд нь барилгын ажлын явцад талбайн байгаль орчны ажилтан авч ажиллуулах үүргийг хүлээнэ.

2025 онд хэрэгжих 19 төслийн хэрэгжилт, гэрээ байгуулсан хугацаа болон дуусах хугацааг Хүснэгт 19-д үзүүлэв.

Хүснэгт 19. Төслийн хэрэгжилт, гэрээ байгуулсан хугацаа болон дуусах хугацаа.

№	Гэрээний дугаар	Гэрээний нэр	Гэрээ байгуулсан хугацаа	Гэрээ дуусах хугацаа	Хэрэгжилт
1	ТЕС-А	Толгойт дэд төвийн мэдээлэл холбооны шугам сүлжээ	Q1/2025	Q4/2026	0%
2	ТЕС-В	Толгойт дэд төвийн цахилгааны хаалттай дэд өртөө ба 10кВ цахилгаан дамжуулах кабель шугам	Q1/2025	Q3/2026	0%
3	ТЕС-С	Толгойт дэд төвийн цахилгааны хуваарилах байгууламжууд ба 10кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугам	Q1/2025	Q2/2026	0%
4	TRDH11-A	Толгойт дэд төвд хийгдэх ариутгах татуургын шугам суурилуулалтын ажил	Q1/2025	Q4/2026	0%
5	TRDH11-B	Толгойт дэд төвийн авто замын ажил	Q1/2025	Q4/2026	0%
6	TRDH11-C	Толгойт дэд төвийн насосын станц болон усан шугам сүлжээ	5/23/2023	7/30/2025	84.25%
_7	TRDH14-A	Толгойт дэд төвийн авто зам, дулааны сүлжээ болон бусад дагалдах ИШС (1р хэсэг)	Q4/2024	Q4/2026	0%
8	TRDH14-B	Толгойт дэд төвийн авто зам, дулааны сүлжээ болон бусад дагалдах ИШС (2р хэсэг)	Q4/2024	Q4/2026	0%
9	SHTL-C1	Сонгинохайрхан дүүргийн 9 дүгээр хороонд 3x3 сагсан бөмбөгийн талбайн тохижилт	Q2/2025	Q4/2025	0%
10	SHTL-C2	Сонгинохайрхан дүүргийн 10 дугаар хороонд бичил тохижилтын ажил	Q2/2025	Q4/2025	0%
11	SHTL-C3	Сонгинохайрхан дүүргийн 8 дугаар	Q2/2025	Q4/2025	0%

**2025 онд хэрэгжүүлэх Толгойт дэд төвийн Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөө,
Орчны Хяналт Шинжилгээний Хөтөлбөр**

		хороо, нийслэлийн 261 дүгээр цэцэрлэгийн гадна нэмэлт авто зогсоолын ажил			
12	SHTL-C4	Сонгинохайрхан дүүргийн 8 дугаар хороонд, бизнес инкубатор төвийн гадна нэмэлт авто зогсоолын ажил	Q2/2025	Q4/2025	0%
13	SHTL-C5	Сонгинохайрхан дүүргийн 8 дугаар хороо, Баянхошуу бизнес инкубатор төв болон нийслэлийн 261 дүгээр цэцэрлэгийн барилгын гадна фасадны засварын ажил	Q2/2025	Q4/2025	0%
14	SHTL-D	Сэлбэ дэд төв дэх нийтийн зориулалттай ногоон байгууламж ба гадна талбайн тохижилтын ажлууд	Q2/2025	Q4/2025	0%
15	TFP-A	Толгойт дэд төвийн үерийн усны хамгаалалтын суваг (2р хэсэг)	8/7/2023	10/30/2025	35%
16	SHTSC-A	Толгойтын ус, бохир ус, дулааны хоёрдогч холболт (Цэргийн хотхон)	11/15/2023	11/30/2025	44%
17	SHTSC-B	Баянхошуу дэд төв (Оргил)-ын цэвэр, бохир ус, халуун ус, дулаан түгээх шугам сүлжээний нийлүүлэлт, суурилуулалт	9/11/2023	12/31/2025	33%
18	TBC	Толгойт дэд төв сургалтын төв	7/8/2022	5/30/2025	91%
19	TSC+ SHTL-A	1. Толгой дэд төвийн бага сургууль. 320 суудалтай, Ерөнхий боловсролын дунд сургууль. 2. Тохижилт, ногоон байгууламжийн ажил	6/6/2024	12/6/2025	35%

2025 онд авч хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал **252,657,091 төгрөг** болох бөгөөд зардлын хураангуйг Хүснэгт 20-д үзүүлэв.

2025 онд хэрэгжүүлэх Толгойт дэд төвийн Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөө, Орчны Хяналт Шинжилгээний Хөтөлбөр

Хүснэгт 20. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй.

№	Гэрээний дугаар	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	Удирдлага зохион байгуулалт	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал, төгрөг
1	TEC-A	1,186,100	8,212,393.73	-	-	2,100,000	1,100,000	2,280,000	-	14,878,494
2	TEC-B	2,812,850	17,863,989.2	-	-	2,100,000	1,100,000	2,280,000	-	26,156,839
3	TEC-C	2,532,590	15,376,672	-	-	2,100,000	1,100,000	2,280,000	-	23,389,262
4	TRDH11-A	3,017,100	1,175,499.5	-	-	2,100,000	1,100,000	4,560,000	-	11,952,600
5	TRDH11-B	4,060,200	4,636,436.85	-	-	2,100,000	1,100,000	4,560,000	-	16,456,637
6	TRDH11-C	700,000	3,640,764.13	-	-	2,100,000	1,100,000	4,560,000	-	12,100,764
7	TRDH14-A	3,017,100	4,031,204.14	-	-	2,100,000	1,100,000	3,820,000	-	14,068,304
8	TRDH14-B	2,126,570	4,997,023.05	-	-	2,100,000	1,100,000	3,820,000	-	12,017,023
9	SHTL-C1	1,600,000	2,535,046.44	-	-	2,100,000	1,100,000	2,340,000	-	9,675,035
10	SHTL-C2	1,600,000	2,108,246.44	-	-	2,100,000	1,100,000	2,340,000	-	9,248,246
11	SHTL-C3	1,600,000	2,436,035.04	-	-	2,100,000	1,100,000	2,340,000	-	9,576,035
12	SHTL-C4	1,600,000	1,888,160.44	-	-	2,100,000	1,100,000	2,340,000	-	9,028,160
13	SHTL-C5	1,600,000	1,888,160.44	-	-	2,100,000	1,100,000	2,340,000	-	10,055,844
14	SHTL-D	1,600,000	2,915,844	-	-	2,100,000	1,100,000	2,340,000	-	15,468,235
15	TFP-A	1,763,622	7,664,613.264	-	-	2,100,000	1,100,000	2,840,000	-	10,406,754
16	SHTSC-A	2,631,500	1,495,253.76	-	-	2,100,000	1,100,000	3,080,000	-	10,356,004
17	SHTSC-B	-	4,076,004.24	-	-	2,100,000	1,100,000	3,080,000	-	10,109,008
18	TBC	1,616,000	2,953,008	-	-	2,100,000	1,100,000	2,340,000	-	10,109,008
19	TSC+ SHTL-A	4,778,688	8,366,986.6	-	-	2,100,000	1,100,000	2,340,000	-	18,685,674.6
Нийт		37,515,750	98,261,321.26	-	-	39,900,000	20,900,000	55,880,000	-	252,657,091

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1. Мэдээлэл ХОЛБООНЫ ШУГАМ СҮЛЖЭЭ БА ЦАХИЛГААН ЭХ ҮҮСВЭРИЙН УГСРАЛТ (ТЕС).

ТЕС-А	Толгойт дэд төвийн мэдээлэл холбооны шугам сүлжээ ба цахилгаан хангамжийн эх үүсвэрийн угсралт	Холбооны шугам: урт 7.14 км, диаметр: 110мм, байр төв 925м ² болон 272м ² - 2ш Нөлөөлөлд өртөх талбай: 4,767м²
ТЕС-В	Толгойт дэд төвийн цахилгааны хаалттай дэд өртөө ба 10кВ цахилгаан дамжуулах кабель шугам	• 10/0.4кВ хүчин чадалтай хаалттай дэд станц (ХТП)-1 РП, кабель шугам 47500м Нөлөөлөлд өртөх талбай: 24,850 м²
ТЕС-С	Толгойт дэд төвийн цахилгааны хуваарилах байгууламжууд ба 10кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугам	• Цахилгааны кабель шугам: урт= 42500 м, удирдлагын байр 140м ² Нөлөөлөлд өртөх талбай: 21,390м²

Хүснэгт 21. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө-(ТЕС-А, ТЕС-В, ТЕС-С).

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Шаардагдах зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1. Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө					
Газар шорооны ажилд 0.8 га талбайн газрын гадарга, хэвлий өртөж эвдрэл үүсэх	Цахилгааны кабель, шилэн кабель, холбооны шугам тавих, ХТП, холбооны төвийн барилга барих ажилд өртөж эвдэрсэн 0.35 га талбайд талбайд газар шорооны ажил дуусмагц нөхөн дүүргэлт, тэгшилгээний ажлууд хийж, анхны төрх байдалд нь нийцүүлэн хэлбэршүүлэх		Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан	Тухайн цэг дээрх барилгын ажил дуусах үед	Нөхөн сэргээлтийн стандарт MNS 5915:2008, MNS 5916:2008, MNS 5917:2008
Газар шорооны ажлаас 9350 м ³ хаягдал шороон материал үүсэх	9350м ³ хэмжээтэй шороон материалыг шуудууны нөхөн дүүргэлтэд ашиглах ба үлдсэн 2,028 м ³ хэмжээтэй хаягдал шороон материалыг Цагаан давааны хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэн зайлуулах зөвшөөрлийг СХД-ийн хот тохижилтын газраас авч, хог хаягдлын гэрээнд тусган оруулж өгнө. Гэрээт гүйцэтгэгч нь хаягдал шороон материалын хэмжээ, овоолго, ачиж зайлуулсан тоо хэмжээний бүртгэлийг өдөр тутам хөтөлж, 7 хоног бүр ТУН-д тайлагнана.	Газар шорооны ажил явагдах бүх цэгт ТЕС-А, ТЕС-В, ТЕС-С	Барилгын ажлын төсөвт багтсан	Газар шорооны ажил явагдах хугацаанд, 7 хоног бүр	Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам MNS BS 5906:2015 Барилгын хог хаягдлын менежмент, ашиглалтын дүрэм
Газрын гадаргын төрх байдалд түр хугацааны	Газар шорооны ажлаас бий болох шороон материалын овоолгыг үүсгэхдээ орц, гарц, зам талбайг хааж, хөдөлгөөнд саад учруулахгүйгээр тооцож байрлалыг	Газар шорооны ажил явагдах бүх	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан	Газар шорооны ажил явагдах	MNS5916:2008 Газар шорооны ажлын үед үржил

2025 онд хэрэгжүүлэх Толгойт дэд төвийн Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөө, Орчны Хяналт Шинжилгээний Хөтөлбөр

өөрчлөлт орох	сонгох Газар шорооны ажил дуусмагц шороон материалын овоолго байрласан цэгт талбайн цэвэрлэгээ, нөхөн сэргээлт хийх	цэгт		хугацаанд	шимт хөрс хуулалт, хадгалалт
2. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө					
Газар шорооны ажил, барилгын материал тээвэрлэх, ачиж буулгах зэрэг ажлуудаас тоосжилт үүсэж агаар орчныг бохирдуулах	Хуурай өдрүүдэд газар шорооны ажил явагдаж буй цэгүүдэд м ² талбайд 2-4л нормын дагуу тогтмол усалгаа хийх Хүчтэй салхи шуургатай үед тоосжилтыг багасгах үүднээс ачиж буулгах болон газар шорооны ажлыг түр зогсоох Хүчтэй салхи шуургатай үед хөрсний овоолгоос тоосжилт үүсэхээс сэргийлж усалгаа хийх Хаягдал шороон материал, барилгын материал тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх	Газар шорооны ажил явагдах бүх цэгт ТЕС-А, ТЕС-В, ТЕС-С	Усны хэмжээ м ³ ТЕС-А 128.7м ³ х3000=3861,00 ТЕС-В 670.95м ³ х3000=2,012,850 ТЕС-С 577.53м ³ х3000=1,732,590	Барилгын ажлын туршид,	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS4585:2016 Агаарын чанар. Техникийн Ерөнхий Шаардлага
Барилгын ажилд ашиглагдах тоног төхөөрөмж, машин механизмаас хийн хаягдал, бохирдуулагч бодисууд ялгарч агаар орчныг бохирдуулах	Барилгын ажилд ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэгт сар бүр оруулж, утаа их хаядаг, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гаргахгүй байх Тээврийн хэрэгсэл болон хүнд даацын машин механизмын хөдөлгүүрийн тохиргоо, оношилгоо үйлчилгээг тогтмол, чанартай хийх Тээврийн хэрэгслийн утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих аргын стандартын /MNS 5013:2009, MNS5014:2009/ дагуу хянаж зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байлгах	Барилгын ажилд ашиглагдах бүх тээврийн хэрэгсэл, машин механизмууд ТЕС-А, ТЕС-В, ТЕС-С	Барилгын ажлын төсөвт багтсан ОХШХ-т тусган оруулсан	Барилгын ажлын туршид, 7 хоног бүр	MNS5885:2016 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS4990:2010 Хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS4990:2000 Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага
3. Физик орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө					
Кабель шугам тавих нүх шуудуу ухах, булах ажил, барилгын материал тээвэрлэх, ачих, буулгах ажлуудаас дуу чимээ үүсэх	Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникийн үзлэг, оношилгоо, засварыг сар бүр хийж, хэт их дуу чимээтэй, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гарахыг хориглох Дуу чимээ ихтэй ажлуудыг зөвхөн өглөөний 08:00 цагаас оройн 19:00 цагийн хооронд гүйцэтгэх Дуу чимээний мониторинг хэмжилт хийж хяналт тавих	Барилгын ажилд ашиглагдах бүх тээврийн хэрэгсэл, машин механизмууд Барилгын ажлын талбай	Барилгын ажлын төсөвт багтсан ОХШХ-т тусган оруулсан	Барилгын ажлын туршид,	MNS4585:2016 Гадаад орчны дуу чимээний хүлцэх хэмжээ, MNS4995:2015 Ажлын орчинд дуу чимээний давтамж болон хэлбэлзэл

2025 онд хэрэгжүүлэх Толгойт дэд төвийн Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөө, Орчны Хяналт Шинжилгээний Хөтөлбөр

Барилгын болон ахуйн хог хаягдлыг зүй зохистойгоор цуглуулж, зайлуулаагүйгээс физик орчны бохирдол үүсгэх	СХД-ийн тохижилт үйлчилгээний газартай хог хаягдлын гэрээ байгуулж, түүнд хаягдал шороон материал, ахуйн ба барилгын хог хаягдлыг зайлуулах цэг ба тээвэрлэх автомашины улсын дугаарыг тодорхой зааж өгөх	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.	Барилгын ажил эхлэх үед, 2025 оны 2-р улиралд	Хог хаягдлын тухай хууль, MNS 5344: 2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага, Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам
	Барилгын ажил явагдаж буй газруудад хогийн хаягдлын цэг тогтоож, зориулалтын хогийн сав байрлуулах				
	Барилгын түр кемп тус бүрд хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэг тогтоож, хашлага хамгаалалт хийж, тэмдэгжүүлэх				
	Хог хаягдлыг замбараагүй хаях, зөвшөөрөлгүй газарт хураах, цуглуулахыг хатуу хориглох				
	Хог хаягдлын менежмент, талбайн үзлэгийг өдөр тутамд зохион байгуулж хяналт тавих				
	Барилгын түр кемпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулах				
	Барилгын ажил дууссаны дараа хог хаягдлыг цуглуулж зайлуулах, талбайн цэвэрлэгээг бүрэн гүйцэд хийж хяналтын инженерт хүлээлгэн өгөх				
4. Гадаргын ба газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө					
